

БИЧИЛ УУРХАЙЧДЫН САНААЧЛАГА, ТУРШЛАГА



1 – р хэсэг

Тогтвортой бичил уурхай төсөл

**Улаанбаатар
2013 он**

АГУУЛГА

Өмнөх үг	3
“Алтан ус-Аман ус” ТББ Баянхонгор аймгийн Баян-Овоо сум	6
“Баатар вангийн хишиг холбоо” ТББ Сэлэнгэ аймгийн Мандал сум	8
“Байдрагийн хөгжил” ТББ Баянхонгор аймгийн Жаргалант сум	14
“Батсайхан сэтгэл” ТББ Баянхонгор аймгийн Галуут сум	19
“Баянбөмбөгөр” ТББ Баянхонгор аймгийн Бөмбөгөр сум	21
“Бичил уурхайчдын холбоо” ТББ Төв аймгийн Борнуур сум	24
“Дууш мандал хайрхан холбоо” ТББ Сэлэнгэ аймгийн Мандал сум	34
“Хувиараа ашигт малтмал олборлогчдыг дэмжих холбоо” ТББ Баянхонгор аймгийн Баян-Овоо сум	37
“Энх мөнх эргэх холбоо” ТББ Төв аймгийн Заамар сум	45
“Эх орон хамтын хүч” ТББ Дорноговь аймгийн Айраг сум	51
Бичил уурхайчид олон улсын хурал зөвлөгөөнд оролцож байна	57
Олон улсын Бичил уурхайн нийгэмлэг буюу CASM (Communities and Artisanal and Small-scale Mining)	57
Алтны бичил уурхайн сэдэвт олон улсын форум	63
Алтны бичил уурхайн стратеги төлөвлөлтийн семинар	67
Бичил уурхайчид олон улсын туршлагаас судалж байна	69
Филиппин Улсын бичил уурхайн үйл ажиллагааны туршлагаас суралцах аялал	69
Латин Америкийн орнуудын бичил уурхайчдын байгууллагын туршлагаас суралцах аялал	73
Бичил уурхайчид сайн туршлагаас харилцан суралцаж байна	79
“Баатар вангийн хишиг холбоо” ТББ-ын туршлагаас суралцах аялал Сэлэнгэ аймаг, Мандал сум, Дунд буданчийн ам	79
Бичил уурхайчдын улс төрийн идэвхи сайжирч байна	88

ӨМНӨХ ҮГ

Энэ бяцхан номонд бичил уурхайчдын сайн туршлагаас сорчилж багтаахыг зорив.

Монгол Улсад зарим төрлийн байгалийн баялгийг иргэд хувиараа олборлож эхлээд хэдийнээ хорь гаруй жил болжээ. Аливаа юманд анхдагч гэж байна. Алдах, онох бас арга туршлагажих ч гэж байдаг. Бичил уурхайчдын хорь гаруй жилийн товчхон түүхийг мөшгиж харахад тэдний замнал ч амьдралын энэ энгийн логикоос нэг их гажсангүй.

1990-ээд оны эхээр Төв аймгийн Борнуур, Заамар, Баянхонгор аймгийн Жаргалант, Бөмбөгөр, Сэлэнгэ аймгийн Мандал суманд алт олборлож анхдагч нь болж, “нинжа” хэмээн хочлуулж, байгаль орчныг сүйтгэлээ, түмний баялагаас “хумсаллаа” гэж бараг л амтай хэлтэй болгонд ад шоо үзэгдэж явсан иргэд эдүгээ нас сүүдэр тогтож, бичил уурхайн түүхийг бичилцсэн, ажил амьдралын асар их туршлагатай хүмүүс болжээ.

Бичил уурхай эрхлэгчдийг мэргэжлийн бус хүмүүс гэж хэлж ярьдаг. Үүний цаана уул уурхай бол гагцхүү мэргэжлийн хүмүүсийн хийдэг ажил гэсэн санаа цухалздаг юм. Буруутгахад амаргүй. Гэхдээ бас практик дээр сурч болохгүй тийм нарийн мэргэжил үү гэхээр бас тийм бишдэг ээ. Бичил уурхай дээр олон жилийг үдсэн хүмүүстэй ярьж байхад тэдний дотор багш, эмч, төрөл бүрийн зохион бүтээгч гээд байхгүй мэргэжлийн хүн гэж бараг л үгүй. Тэд үндсэн мэргэжилдээ түшиглэн уул уурхайн нарийн ширийнийг ч эзэмшсэн байх юм.

Бичил уурхай дээр тэсэлгээг мэргэжсэн байгууллагаар хийлгэх журамтай. Үнэнийг шуудхан хэлэхэд бичил уурхайчид мэргэжлийн байгууллагаар хийлгэж байгаа юу? Үгүй. Тэд хийж л байгаа шүү дээ. Гэтэл энэ хугацаанд нэг ч тэсэлгээтэй холбоотой осол гарлаа гэж сонсоогүй. Тэд хариуцлагаа бүрэн үүрээд хийдэг байх л даа. Чадаж байнаа даа. Ингээд бодохоор хэрэгжихгүй дүрэм журам гаргаж байснаас хариуцлагыг нь бүрэн өгөөд зөвшөөрөхөд болохгүй ч биш юм шиг ээ. Бичил уурхайчид хариуцлагажиж, бас мэргэшиж байна.

Манайхан хувиараа ашигт малтмал олборлож байгаа

иргэдийг бүгдийг бичил уурхай эрхлэгч гэж буруу ойлгодог, тэгж ярьж ирсэн. Тэгвэл бичил уурхайчин гэж яг хэн юм вэ? Энэ бол нөхөрлөлийн зохион байгуулалтанд орсон, хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа, орлогын албан татвараа төлдөг хэсгийг нь хэлж байгаа юм. 2013 оны нэгдүгээр сарын байдлаар нөхөрлөлийн зохион байгуулалтанд орсон бичил уурхайчин 5000 гаруй болоод байна. Энэ номонд өөрсдийн арга туршлагаасаа хуваалцсан хүмүүс бол бичил уурхайн түүхийг бичилцэж байгаа партизан нар юм.

Осол аваарь гарлаа гэвэл мөн л бичил уурхайтай холбож ойлгодог, тэгж ярьдаг, бичдэг. Үнэндээ зохион байгуулалтанд орсон бичил уурхайчдын хувьд осол аваарь гаргаад байсан тохиолдол бараг байхгүй. Хүний амь нас хохирсон осол бол ер нь гараагүй. Тэгвэл осол хаана, юунаас болж гардаг вэ? Зохион байгуулалтанд ороогүй, хувиараа олборлолт хийдэг иргэд дээр ихэвчлэн тохиолддог. Зохион байгуулалтанд орсноор бичил уурхайчид бие биедээ болоод үйл ажиллагаандаа тавих хяналт сайжирдаг. Тэдэнд байдаг нэг давуу тал нь тэд олборлолт хийх талбайгаа албан ёсоор шийддэг учраас хөөгдөнө, хүчирхийлэлд өртөнө гэж айх аюул байддаггүй, хэн нэгнээс өрсөх, яарч “идэх” гэх шаардлага байдаггүй. Энэ давуу тал “...бидэнд осол аваарьгүй ажиллах боломж олгодог...” гэж туршлагажсан бичил уурхайчид ярьдаг. Энэ бол үнэн.

Баянхонгорын Баян-Овоо сумын Л.Бямбадорж ахлагчтай хамт олон, Сэлэнгэ аймгийн Мандал сумын Түнхэлийн Д.Дамбийсүрэнжав ахлагчтай бичил уурхайчид Перу, Боливид өргөн хэрэглэдэг хэвтээ малталтын аргыг нэвтрүүлснээр нуралт үүсэх аюулыг багасгаж, хөдөлмөр хөнгөвчилжээ.

Иргэд тээрмээ хураалгаж гэртээ мөнгөн усаар алт бариулж байхад Борнуурын хэсэг иргэн Б.Наранцогт, Р.Цогбадрах, Д.Цэнгэл, Б.Ууганбаяр, А.Отгонхишиг нар мөнгөн усгүй баяжуулах цех байгуулах санаа сэдэж уйгагүй хөөцөлдөж Швейцарийн хөгжлийн агентлагийн дэмжлэгийг авснаар тус суманд монголдоо анхных гэж хэлэх мөнгөн усгүй технологи бүхий хүдэр баяжуулах цех байгуулсан юм билээ. Энэ цехийг зарим хүмүүс хоцрогдсон технологитой гэж голонгуй байдаг юм. Тийм л юм бол түүнээс илүү технологитой юм байгуулахад нь мэргэжлийн хүмүүс яаж тусалсан юм бэ? Тийм хэмжээний цех санаачилж байгуулсан тэр хүмүүсийн урмыг бодож дэмжих

юмсан гэж бодогддог. Байгаль орчны яам болохоор байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг нь гаргаж өгөхгүй хэдэн жилээр гацааж байгаа нь бүр ч ойлгомжгүй. Уг нь Монгол Улсын Засгийн газар цех барих зөвшөөрлийг гаргаж, санхүүгийн зээл хүртэл өгсөн юм билээ.

“Заамарын Баярмаа” гэвэл бичил уурхайчид бараг бүгд мэднэ. Энэ хамт олон лицензи эзэмшигч компанитай ойлголцож, олборлолт хийх талбайн асуудлаа зохицуулснаар бичил уурхай эрхлэгчид болон компани, орон нутгийн удирдлага гурван талаар хамтран ажиллах боломжтойг анхлан харуулсан юм.

Бичил уурхайг өлгийдөө байхаас нь авахуулаад орон нутгийнхаа хувиараа ашигт малтмал олборлогч иргэдээ зохион байгуулалттай, байгаль орчиндоо ээлтэй, хариуцлагатай хамт олон болгох гэж түмний төлөө явсан Мандалын Д.Туяа нарын хүмүүст бичил уурхайн талаар хуваалцах үнэтэй санаа оноо их юм.

Бичил уурхайчид нэг үеэ бодвол төрийн тодорхой хэмжээний дэмжлэгтэй, хууль эрхзүйн орчинтой болжээ. Гэвч тэдний өмнө амаргүй сорилт, айдас хүйдэс дагуулсан даваа гүвээ олон байна. Нөгөөтэйгүүр бичил уурхайчдаас өөрсдөөс нь хамаарах юм бас олон байна. Бичил уурхай эрхлэгчид хойшоо биш урагшаа алхах ёстой. Чамлахааргүй арга туршлага хуримтлуулсан, түүнээ баяжуулж, үндэсний хэмжээнд нэгдэж, сул чөлөөтэй яваа ХАМО иргэдээ нөхөрлөлийн зохион байгуулалтанд ороход нь чин сэтгэлээсээ тусалж, осол аваариас урьдчилан сэргийлж, аюулгүй ажиллагааны шаардлагыг хангаж, орон нутгийнхаа төр, захиргааны байгууллагуудтай ойлголцож, аль болохоор ойр зайнаас хамтарч ажиллах шаардлагатай тийм нэгэн мөчлөг үед ирээд байна.

Аль аймаг, суманд харьяалагдаж, хаана ажиллаж, амьдарч байгаагаас үл хамаарч нийтлэг нэг ашиг сонирхол байгааг маш сайн мэдрэх, бидний асуудлыг биднээс өөр хэн ч хөөцөлдөж шийдүүлэхгүй, бид л хувь заяаныхаа төлөө нэгдэн нягтарч уйгагүй явах ёстой гэсэн үзэл бодлоор жигүүрлэж хуулийн хүрээнд ажиллаж амьдрах ёстой.

ТБУТ-ийн Үндэсний захирал
П.Үржинлхүндэв

**БИЧИЛ УУРХАЙЧДЫН ТББ-ЫН
АМЖИЛТААС**

**“Алтан ус-Аман ус” ТББ
Баянхонгор аймгийн Баян-Овоо сум**

Баян-Овоо сумын 2-р багийн нутаг дэвсгэр Алтан-усанд хувиараа ашигт малтмал олборлогч 149 иргэн зохион байгуулалтгүй үйл ажиллагаа явуулдаг байсан. Тэд 6 нөхөрлөл байгуулж зохион байгуулалттай ажилладаг болсон бөгөөд анх 2010 оны 11-р сарын 01-нд Ц.Ганбат, Г.Аюурсэд нарын санаачлагаар “Алтан ус-Аман ус” ТББ байгуулж түүнд нэгдэн орцгоов.

Энэ хугацаанд олборлолтын ажлаа зохион байгуулалттай явуулахын зэрэгцээ гишүүдийнхээ нийгэм соёл, орчин тойрны эмх цэгцийг анхаарч тодорхой ажил төлөвлөн тогтмол хэрэгжүүлж ирсэн байна. Үүнд:

- Долоо хоног бүрийн Бямба гаригт бүх гишүүд орчин тойрондоо цэвэрлэгээ хийх буюу гар аргаар нөхөн сэргээлт хийдэг болов.
- Гишүүн бүрийг ТББ-ын үнэмлэхтэй болгов.
- Хүнсний худалдаа хийж байгаа цэгүүдэд архи болон согтууруулах ундаа зарж буй эсэхэд хяналт тавьж заруулахгүй байх арга хэмжээ авч ажилласан.
- Гишүүдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор сагсан бөмбөгийн талбай байгуулсан болно.



Зураг 1. Алтан ус-Аман ус ТББ-ын гишүүдийн суурьшлын бүс болон олборлолтын талбай



Зураг 2. Алтан ус-Аман ус ТББ-ын гишүүдийн гар аргаар техникийн нөхөн сэргээлт хийсэн талбай

**“Баатар вангийн хишиг холбоо” ТББ
Сэлэнгэ аймгийн Мандал сум**

“Баатар вангийн хишиг холбоо” ТББ 2010 оны 3 сард гишүүддээ үйлчлэх, байгалийн баялгийг зөв зохистой ашиглах, нөхөн сэргээх, хайрлан хамгаалах зорилготойгоор байгуулагдсан бөгөөд жил ирэх тутам зохион байгуулалт нь жигдэрч, хувиараа ашигт малтмал олборлогч иргэдийн хөдөлмөрлөх аюулгүй ажиллагааг хангах, эрүүл мэндийг хамгаалах, архигүй орчин бүрдүүлэх, цэвэр цэмцгэр, зохион байгуулалттай орчинд үйл ажиллагаа явуулах чиглэлээр төрөл бүрийн арга хэмжээ авч хэрэгжүүлж байна. Одоогийн байдлаар манай ТББ 26 нөхөрлөлийн 106 бичил уурхайчдыг нэгтгээд байна.

Манай ТББ-ын гишүүдийн бахархаж явдаг нэгэн зүйл бол бид ерөнхийдөө “нинжа”-ийн арга барилаар үйл ажиллагаа хэзээ ч явуулаагүй явдал юм. Бидний ажиллаж байгаа Бор толгойд Түнхэл тосгоны бичил уурхайчид ашигт малтмал олборлоё гэж шийдсэн эхний өдрөөс л үйл ажиллагаагаа цэгцтэй, эмх журамтай явуулах, олборлолтын газарт архидан согтууруулах ундаа хэрэглэхгүй байх, орчин тойрноо цэвэр цэмцгэр байлгах, хог хаягдлын менежментийг сайжруулах, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм журмыг даган мөрдөж ажиллах талаар ярилцаж тохирон ажилласнаар манай ТББ олборлолт явуулдаг газарт архигүй, цэвэр орчинг бүрдүүлж чадсан юм. Олборлолтын газарт хог хаягдал хаях нэгдсэн цэг, бие засах газруудыг байгуулснаар орчин тойрныг цэвэр байлгах, дэг журамтай ажиллаж амьдрах боломж бүрдүүлэх эх үүсвэрийг тавиад байна.

Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрэм журмыг том үсгээр хэвлүүлэн олборлолтын газар болон нөхөрлөлүүдийн уурхайн аман дээр байрлуулснаар бичил уурхайчдын аюулгүй ажиллагааг хангаж ажиллах нь осол гэмтэл гарахаас урьдчилан сэргийлэх үндэс мөн гэдгийг үргэлж санаж, дагаж мөрдөхөд дөхөм үзүүлдэг болно. ТБУТ-ийн дэмжлэгтэйгээр бичил уурхайчдаас бүрдсэн авран туслах багийг 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр



**Зураг 3. Баатар вангийн хишиг холбоо
ТББ-ын гишүүдийн олборлолтын талбай**

байгуулсан бөгөөд тэднийг Уул Уурхайн Аврах Албаны сургалтын цогцолборт зохион байгуулдаг тусгай сургалтанд хамруулж, шаардлагатай тоног төхөөрөмжөөр ханган ажиллаж байна. Авран туслах баг нь тусгайлан гаргасан хуваарийн дагуу нөхөрлөлүүдийн аманд үзлэг шалгалт хийж зөвлөгөө өгч осол гэмтэл гарахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч байна.



Зураг 4. ХАБ-ын самбар



Зураг 5. Нөхөрлөлийн олборлолтын ам

2012 онд ТБУТ-ын дэмжлэгтэйгээр бичил уурхайчдын байгууллагын жижиг төсөл хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд олборлолтын үйл ажиллагаа явуулдаг Бор толгойн 8 га газарт техникийн нөхөн сэргээлт хийж ашигладаггүй маш олон ам, нүхийг булж тэгшлэн, ажиллах орчноо ая тухтай болгов. Энэ ажилд зэрэгцэн үйл ажиллагаа явуулдаг Пураам компаниас машин техникийн тусламж авч хамтарч ажилласан болно.

Баатар вангийн хишиг ТББ-ын тэргүүн Д.Дамбийсүрэнжав 2011 оны 11 сард Тогтвортой бичил уурхай төслөөс зохион байгуулсан Латин Америкийн Перу, Болив улсын бичил уурхайчдын сайн туршлагаас судлах аялалд оролцсон юм. Уг аялалын үед Перу, Болив улсын алтны үндсэн ордод олборлолт явуулдаг бичил уурхайчдын уурхайн малталтын арга технологиос суралцаж ТББ-ынхаа гишүүн нөхөрлөлүүдэд заан сургаснаар бичил уурхайн анхны хэвтээ малталттай ам гаргаж эхлээд байна. Хэвтээ малталттай ам гаргаснаар осол гэмтэл гарах эрсдэлийг багасгах боломж бүрдэж байна.

Баатар вангийн хишиг холбоо ТББ-ын гишүүд сум, орон нутгаас зохион байгуулдаг нийгэм, соёлын арга хэмжээнд хамт олноороо идэвхтэй оролцдог. 2010 оноос эхлэн ТББ-ын гишүүдийн шинэ жилийн баярын ажиллагааг орон нутгийн



Зураг 6. Олборлолтын хэтээ ам гаргаж байгаа нь.

удирдлага, захиргааны байгууллагын төлөөллийг оролцуулан жил бүр зохион байгуулж хэвшсэн байна.

2012 оны Улсын баяр наадмаар байгууллагаараа хүндэтгэлийн жагсаал хийж нутгийн иргэдийг идэвхжүүлж баяр наадмын өнгийг сайжруулав.



Зураг 7. Баатар вангийн хишиг холбоо ТББ-ын гишүүд орон нутгийн наадмаар жагсаж байгаа нь.

БИЧИЛ УУРХАЙЧДЫН САНААЧЛАГА, ТУРШЛАГА

Орон нутгийн хөгжилд хувь нэмэр хандивлах зорилгоор Түнхэл тосгон, МБАА үүсэн байгуулагдсаны 50 жилийн ойд зориулж орон нутгийг хөгжүүлэх, тохижуулах компани т ажил зохион байгуулж тосгоны зам засах, сайжруулах ажилд ТББ-ын 40 гишүүн 2 өдөр оролцон Түнхэл тосгонруу ордог гол зам болон “Хамар даваа”-ны гүүрийг засаж сайжруулсан бөгөөд ТББ-ын гишүүдээс хандив өргөв. Мөн бичил уурхайчид болон орон нутгийн иргэдийн амралт, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зориулалт бүхий “Ногоон байгууламж”-ийг тохижуулах ажилд ТББ-ын 28 гишүүн 1 өдөр оролцон ажилласнаар энэхүү байгууламжийн ашиглалт сайжирч тосгоны иргэдэд чөлөөт цагаа өнгөрөөх таатай орчин нөхцлийг бүрдүүлж өгсөн.

Орон нутгийн захиргаатай хамтран ажиллах талаар: Түнхэл тосгоны захирагчийн албаны 22 хүний бүрэлдэхүүнтэй баг хувиараа ашигт малтмал олборлогчдын ажлын байранд ирж ажил байдалтай нь танилцах зорилгоор 2 өдөр ажилласан нь хамтран ажиллах, харилцан ойлголцох эх үүсвэрийг тавьсан болно. Мөн орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллаж өөрсдийн үйл ажиллагаа, нөхцөл байдлын талаар орон нутгийн иргэдэд зөв ойлголт өгөх, хамтран ажиллах нөхцөл боллоцоог бүрдүүлж байна. Багийн иргэдийн нийтийн



Зураг 8. Баатар вангийн хишиг холбоо ТББ-ын гишүүдийн зассан Хамар давааны гүүр

хурлын төлөөлөгчидтэй тогтмол уулзаж ярилцан олборлолтын газрыг албан ёсны болгох арга замыг эрж хайж байна.

Хүдэр баяжуулах талаар: Үндсэн ордод олборлолт хийдэг аливаа бичил уурхайчдын нийтлэг асуудал болох хүдэр баяжуулах асуудлыг Борнуурын мөнгөн усгүй технологиор хүдэр баяжуулдаг үйлдвэртэй гэрээ байгуулан хамтран ажиллах замаар шийдвэрлэж байна. Энэхүү хамтран ажиллах гэрээний нөхцөл ёсоор зохион байгуулалтанд орсон бичил уурхайчдын хүдрийг ХАМО компаниас хөнгөлөлттэй үнээр баяжуулах үйлчилгээ үзүүлж байгаа бөгөөд үүнээс гарсан зөрүү мөнгийг нөхөрлөлийн гишүүдийг эрүүл мэнд, нийгмийн даатгалд хамруулах, ТББ-ын өдөр тутмын үйл ажиллагаа явуулах зардалд зарцуулах, хуримтлал үүсгэх чиглэлээр ашиглах юм.

Шударга худалдаа, шударга олборлолт. Хариуцлагатай уул уурхайн холбоо, Шударга худалдааны тэмдэгтийн байгууллагаас санаачлан боловсруулсан Шударга худалдаа, шударга олборлолтын стандартын шаардлагыг хангаж зөв зохистой, ёс суртахуунтай, нийгмийн болон байгаль орчны хариуцлагатай үйл ажиллагаа явуулснаар бидний өдөр тутмын үйл ажиллагаанаас илүү орлого олох, нийгэм, орон нутгийн хөгжилд бодит хувь нэмэр оруулах боломж байгаа гэдгийг



Зураг 9. ШХШО-ын стандартын тухай уулзалт ярилцлагын үеэр

ойлгосноор манай ТББ ТБУТ-ийн дэмжлэгтэйгээр тус системд нэгдэн орох бэлтгэл ажлыг эхлүүлсэн. Энэ ажлын хүрээнд ТББ-ын одоогийн нөхцөл байдлыг стандартын шаардлагын дагуу урьдчилсан байдлаар шалгаж үнэлгээ хийхэд харьцангуй өндөр үнэлгээтэй гарсан нь цаашид үйл ажиллагаагаа улам сайжруулснаар олон улсын стандартын системд нэгдэж улам үр бүтээлтэй ажиллах нөхцөл бололцоо байгааг харуулж байна. Тиймээс манай ТББ үйл ажиллагаагаа цаашид улам сайжруулахаар итгэл төгс ажиллаж байна.

Алтны шударга худалдаа, шударга олборлолтын стандартын системийн чиглэлээр ТБУТ-ийн олон улсын зөвлөх бөгөөд ШХШО-ын стандартыг санаачлагч ARM/FLO-ын төлөөлөл ноён Феликс Хрушкатай нягт холбоотой ажилладаг.

“Байдрагийн хөгжил” ТББ Баянхонгор аймгийн Жаргалант сум

Байдрагийн хөгжил ТББ анх 2008 оны 3-р сарын 15-нд ТБУТ-ын туслалцаа дэмжлэгтэйгээр Жаргалант сумын Мандалын Бөөрөг хэмээх газарт 7 нөхөрлөлийн 68 гишүүнтэй байгуулагдсан бөгөөд одоогийн байдлаар 27 нөхөрлөлийн 192 гишүүн ажиллаж байна. Бичил уурхайчид нөхөрлөлийн зохион байгуулалтанд орж ТББ-д нэгдсэнээр Бөөрөгийн баруун, зүүн салаанд зохион байгуулалттайгаар олборлолтын үйл ажиллагаа явуулдаг боллоо.

Зөв зохистой, зохион байгуулалттай ажил үргэлж сайн үр дагавартай байдагчлан бидний ажиллагаа хөгжлийг дэмжих чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын анхаарлыг татаж, цаашид улам их амжилтанд хүрэхийн эх сурвалж болсон дэмжлэг туслалцааг авч эхэлсэн болно. Эхний үед гишүүд маань хүрз, зээтүү, малтуур мэтийн жижиг багаж хэрэгсэлээр олборлолт хийж хөдөлмөрийн бүтээмж бага байсан бол ТБУТ-ийн хандив тусламжаар нөхөн сэргээлтэнд ашиглах бага оврын трактор, аюулгүй ажиллагааны стандарт, шаардлагыг хангасан тайл, ус татах хөөрөг, мотор, өндөр хүчин чадалтай нойтон баяжуулалтын төхөөрөмж шлюз зэрэг багаж хэрэгсэлтэй болж ажлын бүтээмж сайжирч гишүүдийн орлого нэмэгдсэн. Мөн ТББ-

ын гишүүд, бичил уурхайчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх, чадавх суулгах төрөл бүрийн сургалт семинарт хамруулж эхэллээ.



Зураг 10. Байдрагийн хөгжил ТББ-ын гишүүдийн байршил.

Нөхөрлөлийн гишүүд бичил уурхайчдаас бүрдсэн авран туслах баг байгуулж ТБУТ-ийн дэмжлэгтэйгээр сургалтанд хамруулж шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангав.

Сумын ЗД, ИХ, БОУБ, цагдаагийн байгууллага, хүн эмнэлэг зэрэг албан байгууллагуудтай гэрээ хийн хамтран ажилладаг болсноор төрийн үйлчилгээг хүртэх боломж нэмэгдэж олборлолтын газарт бүртгэлгүй бичил уурхайчид нэвтрэн орж зохион байгуулалтгүй үйл ажиллагаа явуулах, дэг журам, эмх цэгц алдуулахаас урьдчилан сэргийлж чадсан болно.

Өнгөрсөн хугацаанд манай ТББ-ын хүрсэн гол амжилтын нэг бол манай суманд үйл ажиллагаа явуулдаг уул уурхайн “ЖАМП” компанитай хамтран ажиллах гэрээ байгуулж ажилласан явдал юм. Энэхүү гэрээний хүрээнд тус бүр 1.2 га, 0.5 га хэмжээтэй хоёр хэсэг газарт ТББ-ын гишүүн бичил уурхайчид тодорхой төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаа явуулсан бөгөөд олборлосон алтаа гэрээнд тусгасны дагуу ЖАМП компанид зах зээлийн үнэ ханшаар худалддаг байсан нь бидний үйл ажиллагааны үр бүтээлийг нэмэгдүүлэх,



Зураг 11. Өндөр хүчин чадалтай усан баяжуулалтын төхөөрөмж туршиж байгаа нь.

хөдөлмөрийг хөнгөвчлөх зэрэг үнэхээр ач холбогдолтой хамтын ажиллагаа байсан. Мөн компаний зүгээс бидэнд техникийн нөхөн сэргээлт хийхэд дэмжлэг үзүүлж том оврын техникээр хөрс түрэх үйлчилгээ үзүүлсэн билээ.

Бага оврын тракторыг техникийн нөхөн сэргээлт хийхэд ашигладаг болсноос гадна нөхөрлөлүүдийн хүсэлтээр тэдний олборлолт явуулах газрын өнгөн хөрсийг хуулах үйлчилгээ үзүүлдэг болсон бөгөөд энэ үйлчилгээнээс олсон орлогыг ТББ-ын дансанд хуримтлуулж тракторын урсгал засвар, үйлчилгээ, жолоочийн хөлс болон урьд нь гэмтсэн газарт нөхөн сэргээлт хийх зэрэг үйл ажиллагаанд зарцуулдаг болов. Ингэж ажилласны үр дүнд 2008 оноос хойш нийтдээ 10 га газарт техникийн нөхөн сэргээлт хийсэн байна.



Зураг 12. *Техникийн нөхөн сэргээлт хийж байгаа байдал*

Мөн 2011 онд 0.2 га-д биологийн нөхөн сэргээлт хийн бургас тарьж ургамлын үр цацсан. Сум орон нутагт болж буй олон нийтийн ажил болон уралдаан тэмцээнд нэн амжилттай оролцож ирэв. Байгаль орчноо цэвэрлэж, лагерь бүрд хогийн цэг, бие засах газартай болсон. Багаж хэрэгсэл сайжирч, багаар ажиллаж чаддаг, өвчин зовлон тохиолдсон хэн нэгэндээ сэтгэлийн дэм, хандив тусламж их үзүүлдэг болсон.



Зураг 13. Байдрагийн хөгжил ТББ-ын гишүүдийн байгуулсан чацарганы төгөл

Жаргалант сумын бичил уурхайчид болон иргэдийн ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцлийг сайжруулах зорилгоор сумын захиргаа, бичил уурхайчдын ТББ ТБУТ-ийн дэмжлэгтэйгээр сумын нийтийн халуун усны газар барьж байгуулав.



Зураг 14. Жаргалант сумын нийтийн халуун усны газар

“Батсайхан сэтгэл” ТББ Баянхонгор аймгийн Галуут сум

Манай ТББ 2010 оны 4-р сарын 1-нд Галуут сумын 2-р багийн нутаг Хөтлийн нурамтад 128 гишүүнтэй байгуулагдсан бөгөөд түүний зохион байгуулалт, бүтэц нь бүх гишүүдийн хурлаас сонгогдсон

1. Удирдах зөвлөл ба хяналтын зөвлөл
2. Тэргүүн
3. Аврах баг
4. Эмэгтэйчүүдийн зөвлөл
5. Эрүүл мэндийн боловсрол олгох хэсгээс бүрдэнэ.

Бидний зорилго бол тархай бутархай байсан иргэдийг нэгтгэн, нэгэн санаа зорилготой, байгальд хал багатай олборлолтын ажиллагаа явуулж, байгальтай зөв боловсон харьцах, хамт олноороо баг болон ажиллах, эмэгтэйчүүдийн оролцоо, хөдөлмөр хуваарилалтыг шударга зохион байгуулах, гишүүдийн гэр бүлийн дарамт түгшүүрийг багасгах, орон нутгийн иргэдийн хоорондын харилцаа итгэлцлийг нэмэгдүүлэх, гишүүн бүр хөдөлмөрийн хөлсөө шударга хуваарилахад оршиж байгаа юм.



Зураг 15. Батсайхан сэтгэл ТББ-ын хэсэг гишүүд

БИЧИЛ УУРХАЙЧДЫН САНААЧЛАГА, ТУРШЛАГА

ТББ-ын ажлын хүрээнд 2010 оноос эхлэн хөгжлийн сан нээн ажилуулж байгаа бөгөөд энэхүү сангийн хуримтлалаараа сумдаа ажлын байр бий болгох зорилт тавин хэрэгжүүлж байна. Мөн аймаг, сумын төрийн байгууллагууд болон төсөл хөтөлбөрүүдтэй гэрээ байгуулж нягт холбоотой ажилладаг бөгөөд зохион байгуулсан сургалт, семинар, олон нийтийн чанартай ажилд идэвхитэй оролцдог болсноор гишүүдийн нийгмийн идэвх сайжирч олон нийт, иргэдтэй сайн харилцаа тогтоож чадсан болно.

Сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг орон нутгийн уул уурхайн “Хөх тэнгэрийн зам” компанитай гэрээ байгуулан зөвшөөрөл бүхий талбайд нь нөхөрлөлүүд олборлолтын ажиллагаа явуулдаг болов.



Зураг 16. Батсайхан сэтгэл ТББ-ын гишүүд олон нийтийг хамарсан үйл ажиллагаанд идэвхтэй оролцдог.

“Баянбөмбөгөр” ТББ Баянхонгор аймгийн Бөмбөгөр сум

Бөмбөгөр сумын Буйлсанд гар аргаар алт олборлож байсан нутгийн 175 иргэд ТБУТ-ийн дэмжлэгтэйгээр 27 нөхөрлөл үүсгэн зохион байгуулалтанд орж эхэлсэн бөгөөд Баянбөмбөгөр ТББ-ыг 2008 оны 10-р сарын 05-ны өдөр байгуулсан болно.

Орон нутгийн захиргаа, удирдлагатай нягт холбоотой ажиллаж 2009 онд Буйлсанд 4 га талбай, 2010 онд Өөхтөд 2 га талбайг бичил уурхайчид үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрсөн шийдвэрийг сумын ИТХ-аар гаргуулсны дагуу ТББ-ын гишүүд үйл ажиллагаагаа зохион байгуулалттайгаар явуулах нөхцөл боломжийг бүрдүүлсэн. Мөн түүнчлэн ТББ-аас бичил уурхайчдын нөхөн сэргээлтийн ажлыг дэмжих зорилгоор өгсөн жижиг оврын тракторыг ашиглан олборлолт хийж дууссан 6 га талбайд өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан техникийн нөхөн сэргээлтийг хийж сумын ЗДТГ, ИТХ, БОА-нд хүлээлгэн өгч дүгнэлтийг гаргуулав.



Зураг 17. Баянбөмбөгөр ТББ-ын гишүүдийн техникийн нөхөн сэргээлт хийсэн талбай.

Бөмбөгөр сумын ЗД, ШХА/ТБУТ-ийн дэмжлэгтэйгээр төмс, хүнсний ногоо тарих 3 га талбайг 3-р багийн нутаг Бор толгой гэдэг газар хашин хамгаалж, ногоо тарьснаар сумын иргэдийг хүнсний ногоогоор хангадаг болсоноос гадна сумын төвд ногоо хадгалах зоорь барив.



Зураг 18. Баянбөмбөгөр ТББ-ын ногооны талбай

Сумын төвд ТББ-ын эзэмшлийн хашаа барьж төслийн хөрөнгө оруулалтаар иж бүрэн тоногдсон сургалтын болон буудлын гэр барьсан нь ТББ бие даасан үйл ажиллагаа явуулах нөхцлийг бүрдүүлж өгөв. Бичил уурхай эрхлэгчид болон сумын иргэдийн эрүүл ахуй, ариун цэврийн нөхцлийг сайжруулах зорилгоор ТББ-ын гишүүд Бөмбөгөр суманд халуун усны газар барих санаачлага гаргаж ТББ-д дэмжлэг хүсч хандсаныг төсөл хүлээн авч дэмсэнээр сумын халуун усны газар барьсан нь орон нутгийн иргэд, бичил уурхайчид, тэдний гэр бүлийнхэнд ашиг тусаа өгч байна.

Бичил уурхайчдад төрөл бүрийн чиглэлээр оюуны хөрөнгө оруулалт хийгдэж сургалт, семинарт хамрагдсанаар гишүүдийн нийгмийн идэвх харьцангуй сайжирч, хариуцлагатай болж сайн дураараа НД, ЭМД-д хамрагдаж, ХАОАТ төлөх болсон нь иргэд нөхөрлөлийн зохион байгуулалтанд орж ажилласны давуу тал байна. Нөхөрлөлийн зохион байгуулалтанд орж үйл ажиллагаагаа хууль журмын дагуу явуулснаар гэмт хэрэгт



Зураг 19. Бөмбөгөр сумын халуун усны байр

холбогдох, архидаг согтуурах явдал арилсан бөгөөд орчин тойрны ариун цэвэр сайжирч, байгаль орчинд сөрөг нөлөө багатай аргаар олборлолт явуулдаг боллоо.



Зураг 20. Баянбөмбөгөр ТББ-ын гишүүд сургалтын дараа

Баянбөмбөгөр ТББ орон нутгийн төрийн болон ТББ-уудтай хамтран ажиллах гэрээ байгуулан ажилладаг болсноор гишүүд нийгмийн халамж үйлчилгээг хүртэх хамтын уялдаа холбоо сайжирч олон зүйл дээр ач холбогдлоо өгсөөр байна.

**“Бичил уурхайчдын холбоо” ТББ
Төв аймгийн Борнуур сум**

Үйл ажиллагааны эхлэл. Төв аймгийн Борнуур суманд иргэд хувиараа ашигт малтмал олборлож эхлээд 20 шахам жил болж байгаа бөгөөд хувиараа алт олборлолтын орлого Борнуур сумын нийт өрхийн 40%-д шууд, 15%-д шууд бус байдлаар нөлөөлдөг гэж үздэг. Хувиараа ашигт малтмал олборлох нь хөдөө орон нутагт албан бусаар ажлын байр бий болгож олон өрхийн орлогын эх үүсвэр болж байгаа хэдий ч түүнтэй хамт шийдвэрлэхэд хүндрэлтэй олон асуудал, сөрөг үр дагавар гарч байсан бөгөөд түүний нэг нь химийн онц аюултай хорт бодис мөнгөн усыг хууль бусаар хэрэглэдэг явдал байв.

2007 онд Борнуур суманд 800 гаруй “нинжа” хэмээгдэх хувиараа ашигт малтмал олборлогч иргэд байсан бөгөөд 5 цэгт 14 тээрэм ажиллаж мөнгөн усыг зүй бусаар ашиглан нийтдээ 9 га орчим талбай мөнгөн усаар бохирдсон гэсэн судалгаа гарч байв. 2008 оны 1 сард Монгол Улсын засгийн газраас мөнгөн усны хэрэглээг хориглосон шийдвэр гаргаж түүний дагуу цагдаа, хяналтын байгууллагуудын хамтран явуулсан ажиллагаагаар Борнуур суманд мөнгөн ус хэрэглэн хүдэр боловсруулж байсан нийт 14 тээрмийг бүгдийг хурааж устгасан байна. Гэвч мөнгөн усны хэрэглээг бүрэн зогсоож чадаагүйгээр үл барам мөнгөн ус хэрэглэх байдал өрх гэрийн дотор орж илүү аюултай хөнөөл учруулах нөхцлийг нэмэгдүүлжээ.

Тэр үед мөнгөн усны хор хөнөөлийн тухай мэдээлэл түгээх, хувиараа ашигт малтмал олборлогчдыг зохион байгуулалтанд оруулах, мөнгөн усгүйгээр алтны хүдэр боловсруулах арга технологийн судалгаа явуулах зэрэг чиг зорилго бүхий Монгол улсын засгийн газар болон ШХА-ийн хамтарсан Тогтвортой бичил уурхай төсөл Борнуур суманд анхаарлаа хандуулж эхэлсэн юм.

ТБУТ-өөс тодорхой мэдээлэл авсан хувиараа ашигт малтмал олборлогч иргэд нэгдэж өөрсдийн төлөөлөх байгууллага “Бичил уурхайчдын холбоо” ТББ-ыг 2007.10.28-нд байгуулав. Тус ТББ бичил уурхайчдын анхны иргэний нийгмийн

байгууллага бөгөөд одоо Борнуур сумын 283 бичил уурхайчид нэгдээд байна. ТББ-ын үндсэн зорилго бол “сум орон нутгийнхаа нөөц баялаг, давуу талд түшиглэн бичил уурхайн хөгжлийн загвар бий болгох замаар гишүүдийнхээ ажил орлогыг хадгалах” явдал юм.

Засгийн газраас 2008 онд “Бичил уурхайг 2015 он хүртэл хөгжүүлэх дэд хөтөлбөр”, “Хувиараа ашигт малтмал олборлогч иргэдийн үйл ажиллагааг зохицуулах түр журам” зэрэг баримт бичгүүдийг батлан гаргаснаар Бичил уурхайчдын холбоо ТББ-ны зорилго бодитой хэрэгжих эрхзүйн анхдагч орчин бүрэлдэн бий боллоо. Улмаар ТББ-ын удирдах зөвлөлийн 4-р хурлаас “Сумаараа мөнгөн уснаас бүрмөсөн татгалзах, мөнгөн усгүйгээр хүдэр боловсруулах арга технологийг эрж хайх, Засгийн газар болон бусад харилцах боломжтой талуудаас дэмжлэг хүсэх” шийдвэр гаргав. Бичил уурхайчдын холбоо ТББ мөнгөн усны хэрэглээнээс татгалзах уриалга гаргаж өргөн зөвлөгөөн зохион байгуулах, мөнгөн усгүй технологи бүхий хүдэр баяжуулах цех байгуулах саналаа ТБУТ-д хүргүүлж дэмжлэг хүссэн бөгөөд төслийн зүгээс бидний саналыг нааштай хүлээн авч арга зүй, санхүүгийн дэмжлэг үзүүлснээр мөнгөн усгүй технологи бүхий хүдэр баяжуулах цехийн төслийг боловсруулж холбогдох байгууллагуудад хүргүүлсэн юм.

Борнуур, мөнгөн усгүй амьдрал. 2008.02.02-нд Борнуур суманд “Борнуур, мөнгөн усгүй амьдрал” зөвлөлгөөн зохион байгуулж Монгол Улсын ЗГХЭГ, АМГТХЭГ, ШХА, Төв аймийн засаг дарга, ЗДТГ, Борнуур сумын засаг дарга болон Төв аймгийн Борнуур, Жаргалант, Сэлэнгэ аймгийн Баянгол, Мандал сумдын 300 гаруй хувиараа ашигт малтмал олборлогч иргэд оролцов.

Зөвлөлгөөнөөс “Химийн онц хортой бодис мөнгөн усыг хэрэглэхээс бүх нийтээр татгалзах, өөрийн орон гэр, үр хүүхдээ мөнгөн усны хор хөнөөлөөс холдуулах, Монгол Улсын ЗГ, орон нутгийн засаг захиргаа иргэдийнхээ хүний эрх, хөдөлмөрлөх эрхийг хүндэтгэн амьдралын эх үүсвэр, орлого, өөрсөддөө бий



Зураг 21. Борнуур, “Мөнгөн усгүй амьдрал” зөвлөлгөөн

болгож байгаа ажлын байрыг хүлээн зөвшөөрч дэмжиж албан болгох тухай” уриалга гаргаж оролцогчид бүрэн дэмжив. Мөн зөвлөлгөөний үед БУХ ТББ-аас санаачлан боловсруулсан “Алтны хүдэр боловсруулах үйлдвэрлэл, бичил уурхайн менежмент” төслийг зөвлөлгөөнд оролцсон нийт төлөөлөгчдөд дэлгэрэнгүй танилцуулсан. ЗГХЭГ мөнгөн усгүй хүдэр баяжуулах саналыг дэмжихээ илэрхийлж зээл хэлбэрээр санхүүгийн дэмжлэг үзүүлэх боломжтойг мэдэгдсэн. ШХА бичил уурхайгаас хөдөөгийн хөгжилд оруулж байгаа эерэг нөлөөллийг дэмжин хөгжүүлэх, загвар үйл ажиллагаа явуулах санаачлагыг халуунаар дэмжиж байгаагаа илэрхийлж техник технологийн болон бусад шаардагдах дэмжлэг туслалцааг үзүүлэхээ мэдэгдсэн юм.

“Борнуур, мөнгөн усгүй амьдрал” зөвлөлгөөн нь нийгмийн анхаарлын гадна үлдсэн бүлэг өөрсдийн амьжиргааныхаа эх үүсвэр, ажил орлогоо хадгалах санаачлага болсон төдийгүй төрийн байгууллага болон иргэдэд нийгмийн өмнө хүлээсэн үүрэг оролцоог нь сануулсан хамтын ажилгааны эхлэл болсон юм.

Таван талт хэлэлцээр. 2008.11.18 нд “Борнуур, мөнгөн усгүй амьдрал” зорилтыг дэмжигч талууд 2015 он хүртэл Бичил уурхайг хөгжүүлэх дэд хөтөлбөрийн хүрээнд “Борнуур суманд мөнгөн усгүй бичил уурхайг дэмжин хөгжүүлэх тухай” олон талт

гэрээ байгуулан тус тусдаа тодорхой үүрэг хүлээж гарын үсэг зуран баталгаажуулсан юм. Гэрээний талуудыг нэрлэвэл:

- Засгийн газар (АМГТХЭГ): Бичил уурхайн эрх зүйн орчинг бүрдүүлэх талаар оролцох;
- Борнуур сумын засаг дарга: Эрх үүргийн хүрээнд бичил уурхайн үйл ажиллагааг зохион байгуулах талаар оролцох;
- “Бороо гоулд” ХХК: Сүжигт уулын орчмын 58 га газарт олборлолт явуулах боломж олгох;
- БУХ ТББ: Гишүүдээ бичил уурхайн нөхөрлөлийн зохион байгуулалтанд оруулж, үйл ажиллагааг зохицуулах;
- ШХА: Мөнгөн усгүй технологи нэвтрүүлэхэд арга зүйн болон техникийн дэмжлэг туслалцаа үзүүлэх.

Энэхүү таван талт гэрээний гол үр дүн нь Сүжигт уулын орчигдсон уурхай орчмын 58 га талбайг Борнуурын бичил уурхайчдын нөхөрлөлүүд тусгай зөвшөөрөл эзэмшигчийн зөвшөөрөлтэйгээр ашиглах албан ёсны харилцааг баталгаажуулсан явдал болов.



Зураг 22. Таван талт гэрээнд гарын үсэг зурах үеэр

Гэрээний талууд бичил уурхайн хөгжлийн загвар бий болгох зорилтонд нэгдэх замаар химийн хорт бодисын хууль бус хэрэглээг зогсоож, хүн ам, хүрээлэх орчинг хамгаалах, хөдөөд ажлын байр нэмэгдүүлж тогтвортой орлого бий болгох, нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн аюулгүй орчинг сайжруулах,

уул уурхайн салбарын нийгмийн хариуцлагыг тодорхойлох, орон нутгийн нөөц бололцоог эдийн засгийн эргэлтэнд оруулах, албан бус эдийн засгийг албан ёсны болгох зэрэг асуудлыг шийдвэрлэх боломжтой арга замыг тодорхойлохыг эрмэлзсэн билээ.

Хүдэр баяжуулах үйлдвэр ба “ХАМО” компани. 2008.6 сард төслийг санаачлагчид буюу БУХ ТББ-ын Удирдах зөвлөлийн гишүүн нэр бүхий 5 иргэн хувь тэнцүү хөрөнгөө нийлүүлэн үүсгэн байгуулсан “ХАМО” ХХК болон АМГТХЭГ “Ажил гүйцэтгэх тухай” гэрээ байгуулсанаар “Алтны хүдэр баяжуулах үйлдвэр” төсөл албан ёсоор хэрэгжиж эхэлсэн юм.

“Хувиараа алт олборлож байгаа иргэдийн олборлосон хүдрийг баяжуулах үйл ажиллагааг 3-4 газарт туршилтын хэлбэрээр төвлөрүүлэн зохион байгуулах, шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг судалж яаралтай арга хэмжээ авах” гэсэн Засгийн газрын 28 дугаар тогтоолын дагуу Борнуурт жижиг, дунд үйлдвэрийг дэмжих сангаас 5 жилийн хугацаатай 120.0 сая төгрөгийн хүүгүй зээл олгож дэмжлэг үзүүлэхээр шийдвэрлэсэн болно.

ХАМО ХХК анх 17 ажилчинтайгаар ажлаа эхэлж үйлдвэрийн ерөнхий төлөвлөгөөний дагуу дэд бүтцэд холбогдох, барилгын суурь бэлтгэх болон ТБУТ-ийн “Туршилтын цех”-ийн барилга, туршилтын тоног төхөөрөмж угсралтын ажлын туслан гүйцэтгэгчээр ажилласан. 2009 оны 2 сард ТБУТ-ийн “Туршилтын цех” албан ёсоор ашиглалтанд орсноор мөнгөн ус ашиглахгүйгээр алтны хүдэр баяжуулах технологийг тодорхойлох туршилтын ажил эхэлсэн болой.

Үүнээс хойш даруй 4 жил өнгөрсөн бөгөөд энэхүү хугацаанд туршилтын цехийг өргөжүүлж хүдэр баяжуулах үйлдвэрийн хэмжээнд хүргэсэн билээ. Уг мөнгөн усгүй технологи бүхий баяжуулах үйлдвэр нь зөвхөн Монгол Улсад төдийгүй бичил уурхай бүхий бусад улсуудад сайн туршлага болон үнэлэгдэж байна. Үүний жишээ нь Индонез Улсын бичил уурхайчдын байгууллага Борнуурын мөнгөн усгүй хүдэр баяжуулах технологиос суралцаж, ижил төстэй цех байгуулах хүсэлтэй байгаагаар илэрхийлсэн юм. Мөн уг цехийн үйл ажиллагааг гадна дотны зочид төлөөлөгчид үзэж сонирхох дуртай байдаг.



Зураг 23. Борнуурын хүдэр баяжуулах мөнгөн усгүй технологи бүхий цехийн нээлтийн ажиллагаа



Зураг 24. Борнуурын хүдэр баяжуулах үйлдвэр

Туршилтын цехийг албан ёсоор ажиллуулж эхэлснээс хойших хугацаанд ХАМО компани бизнесийн үйл ажиллагаагаа өргөжүүлж баяжуулалтын долоон шугам ашиглалтанд оруулснаас гадна бичил уурхайчид, үйлчлүүлэгчдийн тав тухыг хангасан 30 хүн хүлээн авах хүчин чадалтай зочид буудал, 16 суудалтай хоолны газар байгуулж үйлчилж байна. ХАМО




Зураг 25. Хүдэр баяжуулах цехийн технологийн шугамын туршилт хийж байгаа нь



Зураг 26. ШХА-ийн Ерөнхий захирал Мартин Дахиндэн мөнгөн усгүй технологи бүхий хүдэр баяжуулах цехийн үйл ажиллагаатай танилцаж байгаа нь

компани байнгын 60 ажлын байр бий болгож Борнуур суман дахь хамгийн том объект болж өргөжснөөр орон нутгийн иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлэх, нийгэм, эдийн засгийн хөгжилд бодит хувь нэмэр оруулж байна.



Зураг 27. Швейцарийн Холбооны Улсаас Бээжинд суугаа Элчин сайд Жак де Ватевил мөнгөн усгүй технологи бүхий хүдэр баяжуулах цехийн үйл ажиллагаатай танилцаж байгаа нь



Зураг 28. ХАМО компаний ажилчид УИХ-ын гишүүн Н.Энхболд болон бусад албаны хүмүүсийн хамт



Зураг 29. ХАМО компаний зочид буудал

Мөнгөн усгүй технологи нь бодисын хүндийн жингийн үйлчлэл буюу дэлхийн таталтын зарчмыг үндэслэх бөгөөд хацарт бутлагч, дугуйт тээрэм, шлюзийн угсраа шугам, Holman сэгсрэгч ширээ зэрэг Монгол, Хятад, Англи, Бразил, Канад улсад үйлдвэрлэсэн гол тоног төхөөрөмжийг ашигладаг. ТБУТ-ийн инженер техникийн багийн туршилтын ажлын дүнг Улсын геологийн төв лабораториор баталгаажуулснаар энэхүү технологийн метал авалтын хэмжээг 70-80% байна гэж тодорхойлж баталгаажуулсан болно.

2012 оны байдлаар ХАМО ХХК орон нутагт 60 ажлын байр бий болгож зөвхөн Төв аймгийн Борнуур сум төдийгүй, Баянхонгор, Сэлэнгэ, Өвөрхангай, Өмнөговь, Говь-Алтай гэх мэтчилэн улсын хэмжээнд үндсэн ордод үйл ажиллагаа явуулдаг бичил уурхайчдад үйлчилгээ хүргэж байна. Хүдэр баяжуулах үйлдвэр жилд 3000-4000 тн хүдэр боловсруулж 50-100 кг алт ялгах хүчин чадалтай, давхардсан тоогоор 8000 гаруй бичил уурхайчдад үйлчлэл боломжтой юм. Туршилтын хугацаанд Төв, Баянхонгор, Сэлэнгэ, Өвөрхангай, Хэнтий аймгийн бичил уурхайчдын 2800 тн орчим хүдрийг боловсруулж 40 гаруй кг алт баяжуулсан байна.



Зураг 30. ХАМО компаний эзэмшил газарт цэцэрлэгт хүрээлэн байгуулах ажлын эхлэлийг тавив



Зураг 31. ХАМО компани баяжуулсан алтаа Монгол банкнд тушааж байна

ХАМО ХХК-ийн хамт олон “Хөдөө нутгийн хөгжлийн боломж, иргэдийн бүтээлч чадварыг хөдөлмөр бүтээлээр нотлон харуулна” гэсэн эрхэм зорилготой ажиллаж байгалийн нөөц баялгийг бүтээн байгуулалт, ажлын тогтвортой байр бий болгоход зориулан ашиглаж байна.

**“Дууш мандал хайрхан холбоо” ТББ
Сэлэнгэ аймгийн Мандал сум**

Дууш мандал хайрхан холбоо ТББ гишүүдийнхээ амьдралын баталгааг хангахын тулд хүлээн зөвшөөрөгдсөн хариуцлагатай бичил уурхайг хөгжүүлэх зорилготойгоор 2008 оны 4 сарын 30-нд байгуулагдсан болой.

Олборлолтын газрын асуудлыг шийдвэрлэх талаар: Мандал сумын ИТХ-ын 2012 оны 3-р сарын 19-ны 07 тоот тогтоолоор “Ноёт”-ын 12.29 га талбайг орон нутгийн тусгай хэрэгцээнд авч Ашигт малтмалын газрын Уул уурхайн судалгааны хэлтсийн даргын 2012 оны 4-р сарын 25-ны өдрийн 5/2563 тоот албан бичгээр бичил уурхайн зориулалтаар ашиглаж болох дүгнэлт гарч олборлолтын газрын асуудал албан ёсоор шийдэгдлээ. Одоо ТББ-ын зүгээс гишүүдээ шинэчилсэн бүртгэлд оруулах, нөхөрлөлүүдийн зохион байгуулалтыг сайжруулах, бичиг баримтыг шинэчлэн бүрдүүлэх ажил хийж байгаа бөгөөд сумын Засаг даргатай Бичил уурхайн үйл ажиллагааг зохицуулах журмын дагуу хамтран ажиллах гэрээ байгуулахаар ажиллаж байна.



Зураг 32. Дууш мандал хайрхан холбоо ТББ-ын гишүүд БУ-н холбогдолтой материалыг судалж байгаа нь

Орон нутгийн захиргаа, бусад байгууллагуудтай хамтран ажиллах талаар: Жил бүр сумын ЗДТГ, Онцгой байдлын алба, Байгаль орчны албатай хамтран ажиллах харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурж гэрээ байгуулан ажиллаж байна.

ТББ-ын дэргэдэх эмэгтэйчүүдийн зөвлөл бичил уурхайчин эмэгтэйчүүдийн эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр төрөл бүрийн үйл ажиллагаа явуулдагийн нэг нь бичил уурхайчин эмэгтэйчүүдийг сумын эмнэлгийн эмэгтэйчүүдийн их эмчийн үзлэгт тогтмол оруулж зөвлөгөө авч ярилцлага, уулзалт хийж хэвшсэн явдал юм.



Зураг 33. Олборлолтын газрын зохион байгуулалтын талаар ярилцаж байна.

Дэлхийн зөн ОУБ-тай хамтран ажиллаж 2011 оны 9 сард Мандал сумын бичил уурхайчдын гурван ТББ-ын төлөөллийг Баянхонгор аймгийн Баян-Овоо суманд илгээж, сумын бичил уурхайчдын ТББ-ын туршлагыг судлах, үйл ажиллагаанаас суралцах, туршлага солилцох аялалыг Дэлхийн зөнгийн сахнүүжилтээр зохион байгуулсан. Мөн тус байгууллагаас 3 сая төгрөгийн үнэ бүхий бичил уурхайчдын хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдлыг хангах 128 ширхэг хувийн хамгаалах хэрэгсэл авч өгснийг сумын 3 ТББ-д хуваарилсан.

БИЧИЛ УУРХАЙЧДЫН САНААЧЛАГА, ТУРШЛАГА

Байгаль орчныг хамгаалах, мод тарих талаар: Сум орон нутаг, улс даяар зохион байгуулагдаж байгаа ажилд манай ТББ идэвхитэй оролцож 2011 онд Монгол улсын ерөнхийлөгчийн санаачилсан 1 хүн 1мод аяны хүрээнд Ширхэнцэгийн цэцэрлэгт хүрээлэнд 180 ширхэг модыг Ойн ангийн дарга, инженер нараас мэргэжлийн зөвлөгөө авч тарьсан болно.

2012 оны 5-р сард мод тарих аяны хүрээнд 100 ш модны нүх ухаж хүлээлгэж өглөө.

ТББ-ын дэргэдэх “Авран туслах баг”. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлож байгаа иргэдийн хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, ажлын байрны аюулгүй орчинг бүрдүүлж ажиллахад нь туслалцаа үзүүлэх, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм журмыг таниулах, мөрдүүлж ажиллуулах, бичил уурхайчдыг осол гэмтэл гаргахаас урьдчилан сэргийлэх зорилготойгоор Авран туслах баг байгуулан ажиллуулж байна. Тус баг 2009 оны 8-р сард ТБУТ, УУАА-ны дэмжлэгтэйгээр байгуулагдсан бөгөөд сумын хэмжээнд олборлолт явуулж байгаа газруудад сар бүр тогтмол явж үзлэг шалгалтыг хийж байна. Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны үзлэг шалгалтын дэвтэрийг тогтмол хөтөлж хэвшив. Мандал сумын Онцгой байдлын албатай сар бүр тогтмол сургалт авах гэрээ байгуулан сургалтанд хамрагдаж байна.



Зураг 34. Мод тарих нүх ухаж байгаа нь



Зураг 35. Авран туслах багийн гишүүд

Авран туслах баг Уул уурхайн аврах ажиллагаа-2010 тэмцээнд амжилттай оролцсон бөгөөд авран туслах багийн гишүүд УУАА-наас зохион байгуулдаг сургалтанд тогтмол хамрагдаж мэдлэг чадвараа дээшлүүлж байна.

**“Хувиараа ашигт малтмал олборлогчдыг
дэмжих холбоо” ТББ
Баянхонгор аймгийн Баян-Овоо сум**

Манай ТББ 2009 онд Л.Бямбадорж, Баян-Овоо сумаас аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хуралд сонгогдсон Д.Сайнжаргал нарын санаачлагаар Баян-Овоо сумын Цагаан цахиртад олборлолт явуулж байгаа Баян-Овоо сумын иргэдийг нөхөрлөлийн зохион байгуулалтанд оруулж “ХАМОДХ” нэртэйгээр байгуулагдаж тэргүүнээр Л.Бямбадоржийг сонгон 9 нөхөрлөлийн 78 гишүүнтэйгээр үйл ажиллагаа явуулж эхэлсэн боловч гишүүнчлэл зөвхөн Баян-Овоо сумын иргэдээр хязгаарлагдаагүй, аймгийн төв болон бусад сумдын иргэд нөхөрлөлийн зохион байгуулалтанд орж тус ТББ-д 62 нөхөрлөлийн 490 орчим бичил уурхайчин бүртгэгдсэнээс 36 нөхөрлөлийн 320 орчим уурхайчин олборолтын газар ажиллаж

үйл ажиллагаагаа идэвхтэй явуулж байна.

Борнуур сумын хүдэр баяжуулах цехийн үйл ажиллагааны бичлэг хийж аймаг, сумын удирдлагад үзүүлж мөнгөн усгүй технологийн ач холбогдлыг ойлгуулж чадсанаар аймаг Баруун бүсийн хүдэр баяжуулах цехийг байгуулах болсон. Бичил уурхай эрхлэгч иргэд журмын хүрээнд зохион байгуулалтанд орж нэгдэж чадсанаар өөрсдийн эрх ашгийг хамгаалж сум, орон нутгийн удирдлагатай хамтран ажиллаж байна. Суурьшлийн бүсэд лагерь болгон, бичил уурхай эрхлэгчид сард 1 удаа их цэвэрлэгээнд гарч орчин тойрноо цэвэрлэж хэвшсэн. Мөн иргэдэд согтуурах ундаа зарахгүй байгаа нь нийгмийн хэв журам алдагдах, гэмт хэрэг гарахаас урьдчилан сэргийлэхэд дөхөм үзүүлж байна.


Газрын асуудлаар бичил уурхайчдын төлөөлөл Спейшл майнз ХХК-тай гэрээ хийхээр удаа дараа идэвхтэй уулзалт зохион байгуулж ирсэн бөгөөд 2010 онд 120 хүний бүрэлдэхүүнтэйгээр Улаанбаатар хотод компаний удирдагатай уулзалт зохион байгуулахаар 13 хоног, 2011 онд 80 хүний бүрэлдэхүүнтэйгээр 14 хоног маргааныг шийдвэрлүүлэхээр ажилласан болно.

Удаан хугацааны турш олон дахин оролдсоны үр дүн, Баянхонгор аймгийн болон Баян-Овоо сумын удирдлагын дэмжлэгтэйгээр ХАМОДХ ТББ Спейшл майнз ХХК-д бичил



Зураг 36. ХАМОДХ ТББ-ын гишүүд

уурхайн үйл ажиллагааны ач холбогдлыг ойлгуулж чадсан бөгөөд 2012 оны 10 сарын 25-ны өдөр Баянхонгор аймгийн ИТХ, Спейшл майнз компани болон ХАМОДХ ТББ-ын хооронд Харилцан ойлголцол хамтын ажиллагааны санамж бичигт гарын үсэг зурснаар олборлолтын газрын асуудлыг хууль журмын дагуу шийдвэрлэх эхлэлийг тавьсан. Санамж бичигт тусгасны дагуу 2012 оны 11 сарын 29-ний өдөр Ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй газраас бичил уурхайгаар ашигт малтмал олборлох тухай гурвалсан гэрээг байгуулснаар олборлолтын газрын асуудлыг албан ёсны болгож ТББ-ын гишүүн нөхөрлөлүүдийн олборлолтын ажлын таатай орчин нөхцлийг бүрдүүлж чадсан. Энэ нь гурвалсан гэрээний дагуу хамтарч ажиллах гурав дахь тохиолдол болж байна.



Зураг 37. Харилцан ойлголцол хамтын ажиллагааны санамж бичигт гарын үсэг зурах ёслолын ажиллагааны үеэр

ХАМОДХ ТББ нь Алтны бичил уурхайн Шударга худалдаа, шударга олборлолтын олон улсын системд нэгдэн орж стандартын шаардлагын дагуу байгаль орчны хариуцлагатай, ёс суртахуунтай, зөв зохистой үйл ажиллагаа явуулсны дүнд үр ашигтай ажиллахаар чармайн ажиллаж Шударга худалдааны гэрчилгээжүүлэлтийн бэлтгэл ажлыг базааж байна. Энэхүү хөтөлбөрийн дагуу ТББ-ын хүрээнд сургалт сурталчилгаанд

БИЧИЛ УУРХАЙЧДЫН САНААЧЛАГА, ТУРШЛАГА

хамрагдах, байгууллагын болон нөхөрлөлийн түвшинд бүтэц, зохион байгуулалтыг сайжруулах, олборлолтын газрын зохион байгуулалтыг сайжруулж байгаль орчинд хал багатай үйл ажиллагаа явуулах талаар анхаарч ажиллаж байна.

Алтны шударга худалдаа, шударга олборлолтын стандартын системийн чиглэлээр ТБУТ-ийн олон улсын зөвлөх бөгөөд ШХШО-ын стандартыг санаачлагч ARM/FLO-ын төлөөлөл ноён Феликс Хрушкатай нягт холбоотой ажилладаг.



Зураг 38. БУ-р олборлосон алтны ШХШО-ын стандартын талаар зөвлөх Феликс Хрушка семинар зохион байгуулж байна

Бичил уурхайчид ХХАА-ны дүрмийг чанд мөрдөж тухайн нөхөрлөлийн ахлагч ажилд гарах, шинэ бичил уурхайчинд ажлын байранд хэрхэн ажиллах талаар зааварчилгаа өгч ажилд нь гаргаж байна. 2011 онд Баян-Овоо суманд 13,5 сая төгрөгийн татвар төлсөн бөгөөд нөхөн сэргээлтийн санд 10 сая төгрөг хуримтлуулсан байна. Баян-Овоо сумын засаг даргын тамгын газрын засварт 14 сая 500 мянган төгрөг, 1,2,3-р багийн засаг даргад тус бүр 1 мотоцикль, сумын их эмчид 1 мотоцикль зэргийг бичил уурхайчдаас өгч сум орон нутгийн хөгжилд хувь нэмрээ оруулсан байна.

2011 оны 7-н сард уул усаа тахих арга хэмжээг бичил уурхайчид, ТББ-н удирдлага санаачилж Цагаан цахир уулын

тахилга наадмыг зохион байгуулав. Аймгийн 70 жилийн ойн баяр наадамд бичил уурхайчдаас 2 сая төгрөгийн хандив өргөв. Баянхонгор аймгийн Бууцагаан сумын харъяат Улсын начин Чулуунбатад олимпийн их наадамд оролцох эрх авсантай нь холбогдуулан ТББ-н нөхөрлөлүүд 8 орчим тонн хүдрийг өөрсдийн нөөц бололцоог харгалзан олгосноос 120 гр алт гарсныг Олимпод амжилт гаргахыг ерөөж сэтгэлийн дэм болгон өөрт нь гардуулсан байна. ТББ болон бичил уурхайчид нийгмийн болон бусад үйл ажиллагаанд идэвхтэй оролцох, ТББ-н удирдлага гишүүддээ чиглэсэн олон арга хэмжээг хэрэгжүүлж байна.

ХАМОДХ ТББ-ын тэргүүн Л.Бямбадорж 2011 оны 11 сард Тогтвортой бичил уурхай төслөөс зохион байгуулсан Латин Америкийн Перу, Болив улсын бичил уурхайчдын сайн туршлагаас судлах аялалд оролцов. Уг аялалын үед Перу, Болив улсын алтны үндсэн ордод олборлолт явуулдаг бичил уурхайчдын олборлолтын арга технологиос суралцаж ТББ-ынхаа гишүүн нөхөрлөлүүдэд заан сургаснаар бичил уурхайчид олборлолтын аманд холбоо харилцааны төхөөрөмж ашиглаж эхэлсэн бөгөөд үүгээр аваарь осол, гэмтэл гарах эрсдэлийг багасгах боломж бүрдэж байгаа юм.



Зураг 39. Холбоо харилцааны систем

Мөн түүнчлэн механикжсан өргөгч тайл ашиглахыг нэвтрүүлж үүний үр дүнд бичил уурхайчдын хөдөлмөрийн

үр ашгийг нэмэгдүүлж цаг хэмнэх боломжтой болов. Агааржуулалтын төхөөрөмжийг сайжруулж бүрэн гүйцэд ашигласнаар уурхайн гүнд агааргүй болж осол гэмтэл үүсэхээс урьдчилан сэргийлж байна.



Зураг 40. Уурхайн гүнээс хүдэр гаргах зориулалттай механикжсан тайл

Энэ тайлийг хэрэглэхээс өмнө бид гар тайл хэрэглэдэг байсан бөгөөд 5-10 минутын турш гараар татаж байж 1 шуудай хүдэр уурхайн гүнээс гаргадаг байв. Харин энэ тайлийг ашиглаж эхэлснээр бидний ажлын бүтээмж 4-5 дахин нэмэгдэж 5 минутанд 4 шуудай хүдэр гаргах боломжтой болсон.

Нөхөрлөлийн гишүүн Ж.Шагжсүрэн

Бага олимп. Баянхонгор аймагт 2008 оноос эхэлж аймгийн иргэдийн санал санаачлага, УИХ гишүүн Х.Баттулга гишүүний дэмжлэгтэйгээр Баянхонгорын бага олимпыг 4 жилд нэг удаа зохион байгуулахаар анх хэрэгжиж байсан бөгөөд 2012 оны 8-р сарын 8 наас 12 ны өдрүүдэд 2 дахь удаагаа зохион байгууллаа. Уг наадамд 19 сумын 19 баг, аймгийн төвийн 9 баг, 339-р цэргийн ангийн 1 баг, бичил уурхайчдын ХАМОДХ ТББ-н төлөөлөл нэг баг, нийт 30 багийн 700 орчим тамирчид спортын 8 төрлөөр хүч, хурд, авхаалж самбаагаа сорьж уралдлаа.



Зураг 41. Бага олимпийн нээлтийн ажиллагаа

Тэмцээнд ХАМОДХ ТББ-н баг тамирчид амжилттай оролцож дараах байруудыг эзэлсэн. Үүнд:

- Ширээний теннисээр: -эрэгтэй алтан медаль Маргад
-эмэгтэй хүрэл медаль Батдэлгэр
-холимог төрөл шагналт 4-р байр
- Сагсан бөмбөгийн төрөлд: -эрэгтэй мөнгөн медаль
-эмэгтэй шагналт 4-р байр
- Хүчний 3-н төрөлд: -75 кг-д Цэрэндорж хүрэл медаль
-Жүдо 81 кг-д эрэгтэй мөнгөн медаль
Цэрэндорж
-Үндэсний бөхөөр шагналт 4-р
байранд Мөнхтөр нар тус тус орсон.

Харин багийн дүнгээр 3-р байранд орсон байна.

Наадам. ХАМОДХ ТББ-н гишүүдийн санал санаачлагаар 2011 оны 7 сард олборолт хийж байгаа Цагаан цахиртыг тахих зорилгоор наадам анх зохион байгуулсан бөгөөд жил бүр уламжлал болгохоор шийдвэрлэж 2012 оны 6-р сарын 29 ны өдөр наадамаа дахин зохион байгуулсан байна. Наадамд ТББ-н гишүүн 32 бөх барилдаж Бадархундага нөхөрлөлийн Батмөнхбаатар түрүүлж, Аривжих нөхөрлөлийн Түвшинжаргал үзүүрлэсэн байна. Мөн наадамд азарга, соёолон, их нас, даага зэрэг 4 насны 240 морьд тоосоо өргөсөн байна.



Зураг 42. Баянхонгор аймгийн бага олимпод 3-р байр эзэлсэн ХАМОДХ ТББ-ын баг орон нутгийн удирдлага, нэрт тамирчид, жүжигчдийн хамт

Л.Бямбадорж, Ч.Баянжаргал нар Аймгийн ИХ-ын жуух бичгээр шагнуулсан. Г.Ариунжаргал, Цэцгээ, Алтанхуяг нар Аймгийн ИХ-ын баярын бичгээр шагнуулсан.



Зураг 43. Цагаан цахиртын овооны тахилга наадам

“Энх мөнх эргэх холбоо” ТББ Төв аймгийн Заамар сум

“Энх Мөнх Эргэх Холбоо” ТББ анх 2008 онд Сэлэнгэ аймгийн Мандал суманд байгуулагдсан боловч үйл ажиллагаагаа түр хугацаанд зогсоосны эцэст 2010 оны 4 сараас Төв аймгийн Заамар суманд үйл ажиллагаагаа дахин сэргээж албан ёсоор явуулж эхлэв.

Гурван талт гэрээ байгуулж ажиллах талаар: Аливаа бичил уурхайчдын үйл ажиллагаанд нийтлэг тулгардаг хүндрэлтэй асуудлын нэг болох газрын асуудал манай ТББ-ын гишүүдийн өмнө тулгарсан хамгийн хүндрэлтэй асуудал байв. Энэ асуудлыг шийдвэрлэх зохистой арга замыг хайж цуцалтгүй ажилласны үр дүнд манай ТББ Заамар сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг уул уурхайн компаниудтай Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох үйл ажиллагааг зохицуулах журмын дагуу гурвалсан гэрээ байгуулах боломж байгааг олж харж холбогдох байгууллагууд, “Шижир алт”, “ХОТУ”, “Мондулаан трейд” ХХК зэрэг уул уурхайн компаниудад хандсан. Ийнхүү ажиллах хугацаанд Заамар сумын ЗД, ТБУТ-тэй



Зураг 44. Энх мөнх эргэх холбоо ТББ-ын гишүүд Мондулаан компаний инженер, техникийн ажилчдын хамт

нягт холбоотой байсан бөгөөд эдгээр байгууллагаас бидэнд арга зүйн болон бусад төрлийн дэмжлэг үзүүлж ирсэн юм.

Удаан хугацааны оролдлого, олон удаагийн уулзалтын үр дүнд “Мондулаан трэйд” ХХК-ын ерөнхий захирал Ш.Лхамсүрэн бидэнд боломж олгож 2011 оны 9-р сарын 15-наас Заамар сумын ЗД, ЭМЭХ ТББ болон МДТ ХХК-ын хооронд гурвалсан гэрээ байгуулан ажиллаж эхлэв. Энэхүү гурвалсан гэрээний хүрээнд ЭМЭХ ТББ-ын гишүүн 50 бичил уурхайчин Төв аймгийн Заамар сумын Хайлааст багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа МДТ ХХК-ийн ашиглалтын тусгай эрх бүхий газарт тусгайлан гаргасан хуваарийн дагуу уурхайн инженер техникийн ажилтан ажилчдын удирдлага зааварчлагын дагуу олборлолтын үйл ажиллагаа явуулдаг болов.

Уурхайн том компанид ашигладаг том оврын машин техникээр олборлолт хийхэд ил уурхайн шал болон булан тохойд тодорхой хэмжээний алт үлддэг бөгөөд үүнийг бичил уурхайн аргаар олборлоход тохиромжтой байдаг. ЭМЭХ ТББ-ын гишүүн бичил уурхайчид компаниас гаргасан хуваарийн дагуу долоо хоногт 3-4 удаа ил уурхайн шаланд үлдсэн алт агуулсан шороог цуглуулж нойтон баяжуулалтын аргаар угааж баяжуулсан алтаа компанид тухайн үеийн зах зээлийн үнээр худалддаг.

МДТ ХХК-ий зүгээс хамтарч ажилладаг бичил уурхайчдад нийгмийн асуудлаар болон хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалт зохион байгуулах, олборлосон хүдрийг нь баяжуулалтын хэсэгт зөөж аваачих тээврийн хэрэгсэлээр хангах, баяжуулалтанд ашиглах усаар хангах мэтчилэн төрөл бүрийн дэмжлэг үзүүлж ажилласнаар эдгээр бичил уурхайчдын хийж байгаа ажилдаа хандах хандлага өөрчлөгдөж өөрөө өөртөө итгэлтэй байж зөв зохистой арга замаар үйл ажиллагаа явуулах нь сэтгэл санааны болон эдийн засгийн хувьд хамгийн зөв арга зам мөн гэдэг ухамсарыг суулгаж өгсөн болно.



Зураг 45. Мондулаан компани ХХАА болон нийгмийн чиглэлийн сургалт зохион байгуулдаг



Зураг 46. Олборлолтын үеэр

Энэ хугацаанд бид нийтдээ 1,931.42 гр алт олборлож 89,465.800 төгрөгийн орлого олсон бөгөөд нөөцийн болон компаний татварт 32,301.260 төгрөгийг тушаасан. Мөн ТББ-ын гишүүд эрүүл мэнд, нийгмийн даатгалд хамрагдаж хүн амын орлогын албан татвар төлж байна.

Энэхүү гурвалсан гэрээг байгуулж ажилласнаар талууд харилцан ойлголцож тодорхой хэмжээгээр ашиг тус хүртэж байгаа. Манай МДТ ХХК өмнө нь Заамар суманд хувиараа ашигт малтмал олборлож байгаа иргэдтэй маш их зөрчилдөөнтэй байсан. Тэд компанийн олборлолт явуулж байгаа газарлуу олноор дайрах, шөнийн цагаар нууцаар нэвтэрч орсноор ажиллаж байгаа машин техникт дайруулж эд эрхтэнээрээ гэмтэх, амь насаа алдах, компанийн харуул хамгаалалттай зөрчилдөх мэтчилэн маш их зөрчилдөөн үүсгэж байсан бөгөөд иймэрхүү асуудал гарахаас сэргийлэх үүднээс компани харуул хамгаалалтаа чангатгах, сөрөг арга хэмжээ авах зэргээр ихээхэн хэмжээний хөрөнгө мөнгө зарцуулдаг боловч асуудал улам газар авсаар байсан юм. Харин ЭМЭХ ТББ-тай хамтарч ажилласнаар зохион байгуулалтгүй үйл ажиллагаа явуулдаг бичил уурхайчдын зүгээс компанийн хэвийн үйл ажиллагаанд нөлөөлөх сөрөг нөлөө буурснаас гадна эдийн засгийн хувьд ч компанид тодорхой үр дүн өгч байна.

МДТ ХХК-ын ерөнхий захирал Ч.Лхамсүрэн



Зураг 47. Баяжуулалтын хэсэг

Гурвалсан гэрээ байгуулж ажиллахад Заамар сумын ЗД, Хайлааст 3-р багийн ЗД, байгаль орчны байцаагч нар дэмжлэг үзүүлж энэхүү гэрээний хүрээнд явуулж байгаа үйл ажиллагааг бодит үр дүнтэй болгохыг эрмэлзэж байв.

Манай сумын нутаг дэвсгэрт нийтдээ 1000 гаруй иргэд хувиараа ашигт малтмал олборлох үйл ажиллагаа явуулдаг бөгөөд эдний төлөөлөл болох 50 хүн гурвалсан гэрээ байгуулж ажиллаж эхэлсэн нь үр дүнгээ илтэд өгч байна. Ингэж ажилласнаар бичил уурхайчид аюул осол багатай, зөвшөөрөгдсөн нөхцөлд тайван үйл ажиллагаа явуулж тогтмол орлого олох боломжтой болсноос гадна эрүүл мэнд, нийгмийн даатгалд хамрагддаг болов. Мөн орон нутгийн зүгээс зохион байгуулалтгүй үйл ажиллагаа явуулдаг ХАМО иргэдийн зүй бус үйл ажиллагааг зохицуулах зорилгоор хүн хүч гаргаж, хөрөнгө мөнгө зарцуулж чирэгдэл болдог байсан бол одоо наад зах нь эдгээр 50 хүн тэр чиглэлээр ажиллах шаардлагагүй болж байна. Мөн түүнчлэн хүн амын орлогын албан татвар төлдөг болсноор сумын зарим үйл ажиллагааг хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлж байна.

Заамар сумын засаг дарга Д.Болормаа

Гурван талт гэрээний хэрэгжилтийн үр дүнг бичил уурхайчдын олон нийтийн хүртээл болгох талаар: Энэхүү гэрээний дагуу 6 сар ажиллаж тодорхой амжилтанд хүрснийг Заамар суманд ажиллаж байгаа бусад уул уурхайн компаниуд болон хувиараа ашигт малтмал олборлогчдод танилцуулах, тэднийг энэ жишгээр зохион байгуулалттай, харилцан ойлголцож ажиллахыг уриалах зорилгоор ЭМЭХ ТББ-аас санаачлан “Бичил уурхайн хууль тогтоомжийн хэрэгжилт” сэдэвт гурван талын зөвлөлдөх уулзалтыг Төв аймгийн Заамар суманд 2012 оны 3 сарын 14 нд зохион байгуулав.

Зөвлөлдөх уулзалтын үеэр ЭМЭХ ТББ, МДТ ХХК хамтын ажиллагааны туршлага, түүний үр дүнг танилцуулж зөвлөгөөнд оролцогсодтой санал солилцов. Энэхүү зөвлөлдөх уулзалтын үр дүнд Заамар суманд үйл ажиллагаа явуулдаг бичил уурхайчдын “Тосон Заамар-ундрага” ТББ, хөрш зэргэлдээ Булган аймгийн Бүрэгхангай сумын бичил уурхайчдын “Бодь алт” ТББ-д шинээр байгуулагдаж хууль журмын дагуу зохион байгуулалттай үйл ажиллагаа явуулах зорилго тавин ажиллаж байна.

БИЧИЛ УУРХАЙЧДЫН САНААЧЛАГА, ТУРШЛАГА



Зураг 48. Зөвлөлдөх уулзалтын үеэр ЭМЭХ ТББ-ын тэргүүн Д.Баярмаа байгууллагынхаа туршлагаас танилцуулж байна



Зураг 49. Мондулаан компаний Ерөнхий захирал Ш.Лхамсүрэн бүлгийн ажлын үр дүнг танилцуулж байгаа нь

“Эх орон хамтын хүч” ТББ Дорноговь аймгийн Айраг сум

Айраг суманд анх 2000 оны үеэс иргэд хувиараа жонш олборлож эхэлсэн бөгөөд зохион байгуулалтгүй, эмх замбараагүй үйл ажиллагаа явагдаж үүнийг дагалдсан сөрөг үр дагавар байнга үүсдэг байв. Тэдгээрийн нэг нь Айраг суманд үйл ажиллагаа явуулж байгаа Хятадын хөрөнгө оруулалттай компаниуд болон орон нутгийн бичил уурхайчдын хооронд үүссэн зөрчилдөөн юм. Иймэрхүү байдал газар авч 2010 онд монгол залуу амь насаа алдсан эмгэнэлт явдал гарч тэр үеэс бичил уурхайчид хамтарч нэгдэн асуудлыг шийдвэрлэх нь зүйтэй гэдгийг ойлгож “Эх орон хамтын хүч” ТББ-ыг байгуулсан. Одоо манай ТББ-д Айраг сумын жонш болон өнгөт чулуу олборлодог 20 нөхөрлөлийн 100 гаруй бичил уурхайчид нэгдэж байна.

Бичил уурхайчдын нөхөрлөлүүд ТББ-д нэгдэн орж дуу хоолойгоо нэгтгэснээр тэдний өмнө тулгарч байгаа нийтлэг асуудлууд, тухайлбал олборлолтын газрын зөвшөөрөл, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа, жоншны борлуулалт зах зээл, дотоод зохион байгуулалт, орон нутгийн хэмжээнд



Зураг 50. Айраг сумын өнгөт чулуу олборлогч бичил уурхайчдын олборлолтын газар

бий болгосон хатуу дэглэм журмыг зөөллөх гэх мэтчилэн олон тулгамдсан асуудлыг шийдвэрлэхийн төлөө ажиллаж байна. Одоогийн байдлаар бидний хүрсэн хамгийн том амжилт бол “Эх орон хамтын хүч” ТББ Айраг сум болон Дорноговь аймгийн хэмжээнд албан ёсоор хүлээн зөвшөөрөгдсөн байгууллага болж бэхжиж чадсан явдал юм.

Сум, орон нутгийн хэмжээнд байгууллага хамт олон, олон нийт бидний дуу хоолой, хөндсөн асуудлыг анхааран сонсож нухацтай хүлээн авч хамтарч ажиллах хүсэл сонирхолтой болсон байна. Манай ТББ сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын сар бүрийн нэгдсэн хуралдаанд албан ёсоор оролцдог бөгөөд уг хуралдааны үеэр байгууллагын үйл ажиллагаа, төлөвлөгөө, ололт амжилт болон тулгарч байгаа хүндрэлтэй асуудлын талаар ярилцдаг юм.



Зураг 51. ТББ-ын хүрээнд аймаг, сум орон нутгийн удирдлагууд, холбогдох албаны хүмүүстэй нягт холбоотой ажилладаг



Зураг 52. Өнгөт чулууны олборлолтын газрын гэрээнд гарын үсэг зурж байна

Гар урлалын цех. Жонш, өнгөт чулуу болон Айраг сумын нутаг дэвсгэрт элбэг байдаг байгалийн чулуугаар гар урлал, бэлэг дурсгалын зүйл хийх, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх зориулалттай жижиг цех байгуулах санаачлагыг 2010 онд гаргасан бөгөөд энэхүү санаачлагыг хэрэгжүүлэхэд



Зураг 53. Жоншны бичил уурхайчдын олборлолтын газар

БИЧИЛ УУРХАЙЧДЫН САНААЧЛАГА, ТУРШЛАГА

тусламж дэмжлэг авахаар орон нутгийн захиргаа болон ШХА /ТБУТ-д хандсаныг нааштайгаар хүлээн авч дэмжлэг үзүүлэхээр болсон. Энэ ажлын хүрээнд бид хэрэгцээ шаардлага, зах зээл, тоног төхөөрөмж, орон нутагт байгуулах боломж бололцооны талаар судалгаа хийсний дараа цех байгуулах ажлыг эхлүүлээд байна.



Зураг 54. Бичил уурхайчдад чулуугаар бүтээгдэхүүн үйлдвэрлэх ур чадвар олгох сургалтын үеэр

Цех байгуулах санаачлагыг Айраг сумын ЗД, ИТХ-ын зүгээс дэмжиж байраар хангах, заах зээлийн судалгаа хийх, орон нутгийн жуулчид, зочид ирдэг Хамрын хийд зэрэг газарт бүтээгдэхүүн худалдаалах боломж бүрдүүлж өгөх болон бусад шаардлагатай туслалцаа үзүүлэх чиглэлээр оролцож байна. Бичил уурхайчдын ТББ цехэд ажиллах хүн хүч, бүтээгдэхүүн үйлдвэрлэх түхий эд, цехийн байрны засвар, тохижилт, өдөр тутмын тогтвортой ажиллагаа, засвар үйлчилгээ, хэвийн ажиллагааг хариуцах бөгөөд одоогийн байдлаар цехийн байрыг засаж бэлэн болгох ажил эхлээд байна. Энэхүү санаачлагыг зөвхөн сумын захиргаанаас дэмжээд зосоогүй, Дорноговь аймгийн удирдлага мөн дэмжиж тал бүрийн туслалцаа үзүүлсэн. Дорноговь аймгийн Засаг дарга П.Ганхуягийн захирамжаар тус гар урлалын цехийг байгуулах ажлын хэсгийг байгуулж мэргэжил,

арга зүйн зөвлөмжөөр хангаж ажилласан. Аймгийн ИХТ-ийн дарга Г.Ганбаатар цехийн байрны засвар хийхэд хувиасаа 900.000 төгрөг хандивласан.

ТБУТ-ийн зүгээс бичил уурхайчдын чулуугаар гар урлалын бүтээгдэхүүн үйлдвэрлэх ур чадварыг хөгжүүлэх сургалтанд хамруулах, шаардлагатай судалгаа хийх, онол арга зүйн зөвлөх үйлчилгээгээр хангах, тоног төхөөрөмж нийлүүлэх, цех байгуулах чиглэлээр дэмжлэг үзүүлж байна.



Зураг 55. Ур чадварын сургалтын үеэр хийсэн бүтээгдэхүүн

Энэхүү цехийг байгуулснаар бичил уурхайчид бид Айраг сумын брэндийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж нэр алдраа орон нутаг, улсын хэмжээнд төдийгүй олон улсын хэмжээнд цуурайтуулах итгэл найдвар дүүрэн ажиллаж байна. Мөн түүнчлэн гар урлалын цехийг ажиллуулах бүтэц зохион байгуулалтын асуудлыг оновчтойгоор шийдвэрлэх нь тус цехийг үр ашигтай ажиллуулах үндэс суурь болох учраас хамт олноороо хэлэлцэж холбогдох байгууллагуудаас зөвлөгөө авсаны үр дүнд Говь нутгийн чулуу хоршоог 2012 оны 11 сарын 28 нд байгуулж бичил уурхайн үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжийн тоог нэгээр нэмэгдүүллээ.



Зураг 56. Бичил уурхайчдын хийсэн бүтээгдэхүүн



Зураг 57. Говь нутгийн чулуу хоршооны анхны хурлын үеэр

**БИЧИЛ УУРХАЙЧИД ОЛОН УЛСЫН ХУРАЛ
ЗӨВЛӨЛГӨӨНД ОРОЛЦОЖ БАЙНА**

Бичил уурхайн үйл ажиллагаа нь эрт дээр үеэс үүсэн бий болсон боловч манай улсын хувьд харьцангуй шинэ ойлголт юм. Хэдий тийм боловч бичил уурхайн асуудлаар зохион байгуулдаг олон улсын хурал зөвлөлгөөнд идэвхтэй оролцож бичил уурхай хөгжсөн бусад орнуудын туршлагаас суралцахын зэрэгцээ өөрсдийн бий болгосон сайн туршлагаасаа хуваалцдаг болсон билээ. Монголын бичил уурхайчдын энэхүү богино хугацаанд бий болгосон сайн туршлагын тоонд хууль эрх зүйн орчин бүрдүүлсэн, мөнгөн усгүй технологи бүхий баяжуулах цех байгуулсан, зохион байгуулалтанд орж хамт олон бүрдүүлэн ажиллаж байгаа зэрэг нь зүй ёсоор ордог юм.

**Олон улсын Бичил уурхайн нийгэмлэг буюу CASM
(Communities and Artisanal and Small-scale Mining)**

Олон улсын Бичил уурхайн нийгэмлэг (CASM) нь Английн Засгийн газрын Олон Улсын Хөгжлийн Газар, Дэлхийн Банк болон Францын Засгийн газрын Гео-Шинжлэх ухаан, Эрдэс баялгийн Институтын санаачлагаар 2001 оны 3 сард байгуулагдсан. Бүрэлдэхүүндээ Африкийн (CASM Africa), Ази, Номхон далайн (CASM Asia/Pacific), Латин Америкийн (CASM Latin America), Хятадын (CASM China) гэсэн тив болон бүс орнуудын 4 нийгэмлэгийг багтаадаг.

Буурай хөгжилтэй болон хөгжиж буй орнуудад бичил уурхайн үйл ажиллагаатай холбоотойгоор гарч буй хууль эрх зүй, байгаль, нийгмийн харилцаа, хүний эрх, эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, техник-технологи зэрэг олон чиглэлийн төрөл бүрийн асуудлуудыг шийдвэрлэхэд тухайн улс орны төрийн ба төрийн бус байгууллагуудад дэмжлэг үзүүлэх, санхүүгийн туслалцаа үзүүлэхэд олон улсын оролцоог бий болгох зорилготой байгууллага юм. Дэлхийн өөр өөр улс орнуудын ижил бус орчин нөхцөлд өрнөж буй үйл ажиллагаа, үүсгэл, санаачлагын

БИЧИЛ УУРХАЙЧДЫН САНААЧЛАГА, ТУРШЛАГА

ололт, дутагдал, сургамжуудын талаар мэдлэг хуримтлуулах, бичил уурхайн холбогдолтой бодлого, хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэхэд оролцогч, харилцагч талуудад удирдамж, чиглэл өгөх, туршлага солилцох боломж олгоход үйл ажиллагаагаа чиглүүлдэг байна.

Олон улсын Бичил уурхайн нийгэмлэг нь жил бүр ээлжит чуулганаа хийж асуудлаа хэлэлцдэг бөгөөд тус нийгэмлэгийн Мадагаскар улсад зохион байгуулсан VI, Монгол улсад зохион байгуулсан VII, Бразил улсад зохион байгуулсан VIII, Мозамбик улсад зохион байгуулсан IX чуулганд Ази, Номхон далайн бичил уурхайн нийгэмлэгийн Монголын төлөөлөгч, бичил уурхайчдын болон ШХА-ийн төлөөлөл болон холбогдох яам агентлагийн хууль эрх зүй, техник технологи, байгаль орчны асуудал хариуцсан ажилтнууд оролцож санал бодлоо солилцон бусад орны туршлагаас суралцсан.



Зураг 58. 2006 онд зохион байгуулагдсан CASM-ын 6-р хуралдаанд оролцож байгаа нь



Зураг 59. 2006 онд зохион байгуулагдсан CASM-ын 6-р хуралдаан



Зураг 60. CASM-ын 7-р хуралдааныг Улаанбаатарт зохион байгуулав

БИЧИЛ УУРХАЙЧДЫН САНААЧЛАГА, ТУРШЛАГА



Зураг 61. CASM-ын 7-р хуралдаан дээр ШХА-ын суурин төлөөлөгч Маркус Дубах үг хэлж байгаа нь



Зураг 62. CASM-ын 7-р хуралдааны үзэсгэлэнгийн хэсгээс

БИЧИЛ УУРХАЙЧИД ОЛОН УЛСЫН ХУРАЛ ЗӨВЛӨЛГӨӨНД ОРОЛЦОЖ БАЙНА



Зураг 63. 2008 онд Бразил улсад зохион байгуулсан CASM-ын 8-р хуралдаанд оролцож байгаа нь



Зураг 64. CASM-ын 8-р хуралдаанд оролцогсад: (баруунаас) Ө.Батсайхан (ТБУТ), А.Бүдсүрэн (Сэлэнгэ аймгийн Мандал сумын бичил уурхайчин), Ж.Батзоригт (Баянхонгор аймгийн Жаргалант сумын бичил уурхайчин), Л.Энхбаатар (Төв аймгийн Заамар сумын бичил уурхайчин), Р.Цогбадрах (Төв аймгийн Борнуур сумын бичил уурхайчин).

БИЧИЛ УУРХАЙЧДЫН САНААЧЛАГА, ТУРШЛАГА



Зураг 65. CASM-ын 8-р хуралдаанд оролцогсод



Зураг 66. 2009 онд Мозамбик улсад зохион байгуулсан CASM-ын 9-р хуралдаанд оролцогсод

**Алтны бичил уурхайн сэдэвт олон улсын форум
2010 оны 12-р сарын 7-9
Манила, Филиппин улс**

НҮБ-ийн Байгаль орчны хөтөлбөр болон хамтрагч талууд алтны бичил уурхайн асуудлаар 2010 оны 12-р сарын 7-9-ний хооронд Филиппин Улсын нийслэл Манила хотод олон улсын форум зохион байгуулав.

Алтны бичил уурхайн үйл ажиллагаа олон улс оронд хөгжлийн ихээхэн боломж олгохын хажуугаар хүндрэлтэй асуудлуудыг ч дагуулж байдаг дэлхийн хэмжээний хөгжлийн цогц асуудал гэдгийг нийтээр хүлээн зөвшөөрсөн юм. Дээрх алтны бичил уурхайн үйл ажиллагаан дахь мөнгөн усны хэрэглээтэй холбоотой асуудлуудыг хэрхэн шийдвэрлэх талаар болон энэ салбарт тулгарч байгаа бусад олон асуудлуудыг ярилцаж зөвлөлдөх боломжийг бүрдүүлсэн болно.

Форумын зорилго нь:

- Алтны бичил уурхайн үйл ажиллагааг тойрсон эерэг боломжууд болон хүндрэлтэй асуудлууд, мөнгөн ус эдгээрт хэрхэн холбогдож байгааг тодорхойлж зөвлөлдөх;
- Боломжтой шийдлүүдийг кэйс стади болон эдгээрээс сурсан сургамжууд дээр тулгуурлан тодорхойлж ярилцах;
- Мөнгөн усны талаарх дэлхийн хэмжээний гэрээний утга санааны хүрээнд алтны бичил уурхайн үйл ажиллагааг хэрхэн зохицуулах, үүнд бодлого, хууль эрх зүй, техникийн болон санхүүгийн талаарх бодлого ямар үүрэг гүйцэтгэх талаар ярилцах;
- Алтны бичил уурхайн үйл ажиллагаатай холбоотой асуудлуудыг шийдвэрлэхэд өөр ямар механизм үүрэг гүйцэтгэж болох талаар ярилцах;
- НҮБ-ийн алтны бичил уурхайн хамтын ажиллагааг дээрх асуудлуудыг оролцуулан бэхжүүлэхэд оршиж байв.

Уг форумд бичил уурхайчдыг төлөөлж Төв аймгийн Борнуур сумын БУХ ТББ-ын Удирдах зөвлөлийн гишүүн



Зураг 67. Филиппин улсын нийслэл Манила хотод болсон олон улсын форумын үеэр



Зураг 68. Д.Цэнгэл танилцуулга хийж байна

Д.Цэнгэл оролцож БУХ ТББ болон ХАМО компаний хамтын ажиллагааны талаар танилцуулж туршлагаасаа хуваалцсан байна.

Мөн түүнчлэн Их хурлын гишүүн Ж.Батсуурь, ЭБЭХЯ-ны Уул уурхай, хүнд үйлдвэрийн бодлого төлөвлөлтийн газрын орлогч дарга Ч.Цогтбаатар болон ТБУТ-ийн төлөөлөл оролцож

БИЧИЛ УУРХАЙЧИД ОЛОН УЛСЫН ХУРАЛ ЗӨВЛӨЛГӨӨНД ОРОЛЦОЖ БАЙНА

Монгол улсын бичил уурхайн хууль эрх зүйн орчны талаар танилцуулсан болно.



Зураг 69. Форумд оролцогчид



Зураг 70. Форумд оролцогчид бусад орны төлөөлөгчдийн хамт



Зураг 71. Хуралдааны үеэр

**Алтны бичил уурхайн стратеги
төлөвлөлтийн семинар
2011 оны 3-р сарын 22-24
Сэйм Рип, Камбож Улс**

НҮБ-ийн Байгаль орчны хөтөлбөрөөс хэрэгжүүлж байгаа алтны бичил уурхайн үйл ажиллагаа, түүнд мөнгөн усны хэрэглээг багасгах, хянах чиглэлээр явуулж байгаа хөтөлбөрийн хүрээнд Филиппин, Камбож улсууд өөрийн орны алтны бичил уурхайд чиглэсэн стратегийн төлөвлөгөө боловсруулахад дэмжлэг авчээ. Энэхүү семинарыг дээрх хоёр орны алтны бичил уурхайн нөхцөл байдал болон боловсруулсан стратегийн төлөвлөгөө, түүнийг боловсруулах явцад гарсан хүндрэлтэй асуудлын талаар ярилцах, бусал орнуудад мэдээлэл өгөх зорилгоор зохион байгуулсан юм.

Семинарын үеэр улс орнууд стратегийн төлөвлөгөө боловсруулах явц, түүний хэрэгжилт болон яагаад энэ арга барилыг сонгосон гэх мэт тодорхой асуудал дээр төвлөрч танилцуулга хийсэн байна.

Уг семинарт АМГ-ын Уул уурхай, судалгааны хэлтсийн дарга Ц.Даваацэрэн оролцож бичил уурхайн хууль эрх зүйн



Зураг 72. Семинарт оролцогчид

БИЧИЛ УУРХАЙЧДЫН САНААЧЛАГА, ТУРШЛАГА

орчин бүрдүүлэх үйл явц, түүний хэрэгжилтийн талаар танилцуулга хийсэн. Мөн түүнчлэн бичил уурхайчдыг төлөөлж Төв аймгийн Борнуур сумын бичил уурхайчдын БУХ ТББ-ын Удирдах зөвлөлийн гишүүн Б.Ууганбаяр болон ТБУТ-ийн төлөөлөл оролцож туршлага судалсан байна.



Зураг 73. Семинарын явц



Зураг 74. АМГ-ын Уул уурхай, судалгааны хэлтсийн дарга Ц.Даваацэрэн танилцуулга хийж байна

**БИЧИЛ УУРХАЙЧИД ОЛОН УЛСЫН ТУРШЛАГААС
СУРАЛЦАЖ БАЙНА**

**Филиппин Улсын бичил уурхайн үйл ажиллагааны
туршлагаас суралцах аялал
2010 оны 6 сарын 30-аас 7 сарын 9**

Уг аялалын гол зорилго нь аялалын багийн гишүүдийг бичил уурхайчдыг хөгжүүлэх, зохион байгуулах талаар олон улсын сайн туршлагаас суралцах боломжийг олгон, улмаар Монгол Улсын бичил уурхайчдын холбоо, байгууллагуудын дунд уг туршлагыг нэвтрүүлэхэд оршиж байв.

Аялалын багт Бичил уурхайчдын холбоо, Байдрагийн хөгжил бичил уурхайчдын ТББ-д, бичил уурхайчдын ХАМО компани, АМГ, орон нутгийн захиргаа болон ТБУТ-ийн төлөөлөл багтсан. Аялалын багийн гишүүд бичил уурхайчдын байгууллага, холбоодын бүтэц, зохион байгуулалт, бичил уурхайчдад үйлчилгээ хүргэгч байгууллага болж хөгжсөн арга замнал, том уурхайн компаниуд болон бичил уурхайчдын хоорондын сайн харилцаа холбоог зохицуулдаг арга барилтай холбоотой туршлагаас судалж суралцахаас гадна бичил уурхайн төвлөрсөн баяжуулах цехийн үйл ажиллагаатай танилцаж, орон нутгийн хэмжээнд бичил уурхайн бодлого зохицуулалтын хэрэгжилт, үүнтэй холбоотой гарсан амжилт, тулгарсан бэрхшээлийн талаар судалж суралцан мэдээлэл авсан юм.



Зураг 75. Аялалын багийнхан Филиппин улсын Уул уурхайн яамны Эрчим хүч, байгалийн баялгийн газрын дарга болон холбогдох албаны хүмүүстэй уулзсан уулзалтын дараа

Туршлага судлах аялалын хүрээнд доорх чиглэлээр сайн туршлагуудыг судалж бичил уурхайчдын олборлолтын газраар зочилсон. Үүнд:

- Бичил уурхайн олон нийтийг хөгжүүлэх арга барил болон туршлага
- Бичил уурхайн байгууллага холбоодын зохион байгуулалтын хэлбэр, үйл ажиллагаа болон хөгжил дэвшил
- Бичил уурхайн үйл ажиллагаанаас салбарласан үйлчилгээ үзүүлэх бизнес
- Том уурхайн компаниуд, бичил уурхайчдын байгууллагуудын хоорондын харилцаа холбоо, зөрчлийн менежмент
- Алт, зэсний баяжуулах цехийн үйл ажиллагаа
- Бичил уурхайн хууль эрх зүйн орчин ба бодлогын хэрэгжүүлэлт зэрэгтэй танилцав.



Зураг 76. Уул уурхайн том компани болон орон нутгийн хамтын ажиллагааны талаар “Zambales Diversified Metals Corp.” буюу Замбалесын металлын корпорацийн туршлагаас суралцаж байгаа нь



Зураг 77. Бэнэуэтийн уурхайд

БИЧИЛ УУРХАЙЧДЫН САНААЧЛАГА, ТУРШЛАГА



Зураг 78. Бэнгуэтийн бичил уурхайчдын уурхайн болон баяжуулах цехийн зохион байгууллалттай танилцаж байгаа нь



Зураг 79. Ирсэн зочдоор мод тариулдаг заншлын дагуу Монголын туршлага судлах багийн гишүүд мод тарьж байгаа нь



Зураг 80. Туршлага судлах багийн гишүүд

**Латин Америкийн орнуудын бичил уурхайчдын
байгууллагын туршлагаас суралцах аялал
Перу, Болив Улс
2011 оны 11 сарын 18-аас 12 сарын 2**

Энэхүү аялалын гол зорилго нь аялалын баг доорх чиглэлийн дагуу олон улсын туршлагаас суралцаж улмаар өөрийн орны бичил уурхайн салбарын үйл ажиллагаанд нэвтрүүлэн хөгжүүлэхэд оршиж байв. Үүнд:

- Бичил уурхайн салбарын албажуулалт, түүнд тулгарч байсан хүндрэлтэй асуудлууд, зохицуулсан арга зам,
- Бичил уурхайчдын байгууллагууд, түүний бүтэц, үйл ажиллагаа, тулгардаг хүндрэлтэй асуудлууд, ашиг тус болон тогтвортой байдал,
- Бичил уурхайчдын үндэсний холбоо, түүний хөгжил болон тогтвортой байдал,
- Шударга худалдаа, шударга олборлолтын систем, үүнийг дагалдсан боломжууд, түүнд нэгдэн ороход тулгарч байсан асуудлууд болон ашиг тусын талаар судлах.

Аялалын багт Дууш мандал хайрхан холбоо, Баатар вангийн хишиг, Бичил уурхайчдын холбоо, Энх мөнх эргэх



Зураг 81. Перу, Болив улсын бичил уурхайчдын байгууллагын туршлагаас судлах аялалын баг

холбоо, Хувиараа ашигт малтмал олборлогчдыг дэмжих холбоо зэрэг бичил уурхайчдын ТББ-ын төлөөлөл, ТБУТ-ын төлөөлөл оролцов.

Аялалын хугацаанд холбогдолтой төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөгчид, бичил уурхайчид болон тэдний байгууллагуудтай уулзалт хийж тэдгээрийн хуримтлуулсан туршлага, сургамжаас суралцсан бөгөөд бичил уурхайчдын үйл ажиллагаа явуулдаг газруудаар зочилж тэдний олборлолт явуулдаг арга туршлага, зохион байгуулалт, байгаль орчин, аюулгүй ажиллагааны талаарх арга ажиллагааг, үзэж ажиглаж суралцан өөрийн орны нөхцөлтэй харьцуулан нэвтрүүлж болох боломжийн талаар ярилцаж байв.

Болив улсын бичил уурхайчид бол бичил уурхайгаар олборлосон алтны ШХШО-ын гэрчилгээг авсан анхны хоёр орны нэг гэдгээрээ онцлог юм. Монгол улсын бичил уурхайчдын байгууллагууд мөн бичил уурхайгаар олборлосон алтны ШХШО-ын стандартын системд нэгдэн орж гэрчилгээ аван улмаар үүнийг дагалдах ашиг шимийг хүртэх хүсэл эрмэлзэлтэй үйл ажиллагаа явуулж байгаа учраас Боливын туршлага болон түүнтэй холбоотой сургамжаас суралцах нь чухал ач холбогдолтой байсан бөгөөд аялалын багт ШХШО-ын гэрчилгээг



Зураг 82. Аялалын багийнхан Боливын бичил уурхайчдын нэгдсэн Фенкомин холбооны ерөнхийлөгчтэй уулзах үеэр

авсан Котапата хоршооны хамт олонтой уулзаж олборлолтын газарт зочилж зохион байгуулалт, бэлтгэл, хүндрэлтэй асуудлууд, түүнийг даван туулах арга зам, тэр бүхний эцэст ирэх боломж болон ашиг тусын талаар судалж суралцах завшаан тохиосон юм.



Зураг 83. Котапата уурхайд



Зураг 84. Боливын бичил уурхайчдын *Котапата* хоршооны хамт олонтой уулзаж байгаа нь

Мөн аялалын хугацаанд ШХШО-ын дэмжлэг үзүүлэгч “Cumbre Del Sajama S.A” буюу “Сахама уулын оргил” байгууллагатай уулзалт хийж хэрхэн үйл ажиллагаа явуулдаг талаар асууж суралцав.

Перу улсын бичил уурхайчдын үндэсний холбоо байгуулагдаад нилээд олон жил болсон бөгөөд нэгдэж үйл ажиллагаа явуулах, ашиг сонирхолоо хамгаалах, бичил уурхайчдын дуу хоолойг бодлого боловсруулагчдад хүргэх талаар дэлхийн хэмжээнд хамгийн их туршлага хуримтлуулсан байгууллагын нэг юм. Мөн Перу улс бичил уурхайн хууль эрх зүйн орчин хамгийн сайн бүрдсэн орны нэг бөгөөд түүний хэрэгжилтийг хангах талаар нухацтай арга хэмжээ авдаг нь аялалын багийнхны суралцаж, өөрийн орчин нөхцөлдөө нэвтрүүлэх чухал туршлага байв.

Аялалын баг дээрх чиглэлээр Перу, Болив улсын туршлагаас суралцаж өөрийн улсын БУ-н үйл ажиллагаанд нэвтрүүлэх, багийн хэмжээнд уг аялалаас сурсан сургамжуудыг хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргах, ШХШО-ын системийн талаар зохион байгуулалттай, цэгцтэй, бодит мэдлэгтэй болох, бичил уурхайчдын үндэсний холбоо байгуулах талаар бодит мэдээлэлтэй болж хамгийн тохиромжтой арга замыг

БИЧИЛ УУРХАЙЧИД САЙН ТУРШЛАГААС ХАРИЛЦАН СУРАЛЦАЖ БАЙНА

тодорхойлох, бичил уурхайчдын ТББ-д гишүүддээ илүү идэвхитэй, үр дүнтэйгээр үйлчилгээ үзүүлж, хамтран хөгжих боломжийг бүрдүүлэх чиглэлээр ажиллаж байна.



Зураг 85. Эрчим хүч, уул уурхайн яамны Уурхайн газрын дарга Виктор Вардестай хийсэн уулзалтын үеэр



Зураг 86. Перугийн уурхайд



Зураг 87. Уулзалтын үеэр

**БИЧИЛ УУРХАЙЧИД САЙН ТУРШЛАГААС ХАРИЛЦАН
СУРАЛЦАЖ БАЙНА**

**Баатар вангийн хишиг холбоо ТББ-ын туршлагаас
суралцах аялал Сэлэнгэ аймаг, Мандал сум, Дунд
буданчийн ам
2012 оны 10 сарын 5**



Зураг 88. Туршлага судлах аялалд 11 аймгийн 14 сумын бичил уурхайчдын төлөөлөл оролцов

Сэлэнгэ аймгийн Мандал сумын Түнхэл тосгонд үйл ажиллагаа явуулдаг бичил уурхайчдын “Баатар вангийн хишиг холбоо” ТББ-ын санаачлагаар бичил уурхайчдын дотоодын туршлага судлах анхны аялалыг 2012 оны 10 сарын 5-6 нд зохион байгууллаа. Энэхүү аялалд бичил уурхайн үйл ажиллагаа бүхий 11 аймгийн 14 сумын бичил уурхайчид, тэдний байгуулсан ТББ-ын төлөөлөл болсон 90 гаруй бичил уурхайчид оролцож Түнхэлийн Дунд буданчийн амны Бор толгойд цугларч харилцан ярилцаж хуримтлуулсан сайн туршлага, алдаанаас сурсан сургамж зэргээ хуваалцлаа.

Туршлага судлах аялалын үеэр зочдыг хүлээн авч зохион байгуулсан Баатар вангийн хишиг холбоо ТББ-ын тэргүүн, гүйцэтгэх захирал болон гишүүд байгууллагынхаа дотоод зохион байгуулалт, олборлолтын газрын зохион байгуулалт, олборлолтын хэвтээ ам гаргасан сайн туршлага, нөхөн сэргээлтийн туршлага, хамт олон бүрдүүлэх талаар ТББ-ын удирдлагын арга барил, түүний үр дүн, Шударга худалдаа, шударга олборлолтын стандартын системд нэгдэн орох бэлтгэл хийж байгаа талаар танилцуулсан нь бусад ТББ-д санаа авах, үйл ажиллагаагаа сайжруулах урам зоригийг өгсөн юм. Мөн түүнчлэн аялалд оролцсон бусад ТББ-д, бичил уурхайчдын төлөөлөл өөрсдийн хуримтлуулсан туршлагаасаа ярьж ололт амжилт, алдаа оноогоо хэлэлцэв.

Аялалын хөтөлбөрт нийтийн цэнгүүн, спортын уралдаан тэмцээн оруулсан нь аялалын багийнхныг хөгжөөж алжаал тайлах сайхан боломжийг бүрдүүлсэн юм. Цэнгүүний үеэр бичил уурхайчдын хамт олны дунд нийтийн бүжгийн аврага хос шалгаруулах тэмцээн зохион байгуулахад нэгдүгээр байрыг Түнхэлийн С.Дангаасүрэн Борнуурын Р.Түмэндэмбэрэл, хоёрдугаар байрыг Хэнтийн Н. Энхтайван Түнхэлийн Г.Дэнсмаа, гуравдугаар байрыг Баянхонгорын Д. Бямбадорж, Заамарын Н.Баярмаа нар тус тус эзлэв.

Спортын арга хэмжээний үеэр мөн гар бөмбөг, ширээний теннисний аварга шалгаруулав. Гар бөмбөгийн тэмцээнд Баянхонгор аймгийн эрэгтэй эмэгтэй холимог баг нэгдүгээр байр, Дорноговийн эрэгтэй эмэгтэй холимог баг хоёрдугаар байрыг эзлэв. Ширээний теннисний тэмцээнд эрэгтэйчүүдээс Хэнтийн Н.Энхтайван нэгдүгээр байр, Баянхонгорын Д.Бямбадорж хоёрдугаар байр, Өмнөговийн Г.Бямбадорж гуравдугаар байр эзэлсэн бөгөөд эмэгтэйчүүдээс Бүрэгхангайн М. Батцэнгэл нэгдүгээр байр, Мандалын Ш. Цэцэгмаа хоёрдугаар байр, Борнуурын Р.Түмэндэмбэрэл гуравдугаар байр эзэлж амжилттай оролцлоо.



Зураг 89. Туршлага судлах аялалын нээлтийн ажиллагаа



Зураг 90. Түнхэл тосгоны Засаг дарга Раднаабазар аялалын багийнхныг угтан авч орон нутгаа танилцуулав



Зураг 91. Туршлага судлах аялалын үеэр Баатар вангийн хишиг холбоо ТББ-ын тэргүүн болон гишүүд олборлолтын газрын зохион байгуулалтын талаар зочдод танилцуулж байна



Зураг 92. Туршлага судлах аялалын үеэр бичил уурхайчид олборлолтын амны зохион байгуулалттай танилцаж байгаа нь



Зураг 93. Туршлага судлах аялалын үеэр Баатар вангийн хишиг холбоо ТББ-ын тэргүүн болон гишүүд олборлолтын газрын зохион байгуулалтын талаар зочдод танилцуулж байна



Зураг 94. Туршлага судлах аялалын багийнхан Баатар вангийн хишиг холбоо ТББ-ын гишүүн нөхөрлөлийн гаргасан хэвтээ малталт бүхий олборлолтын амыг үзэж танилцаж байгаа нь



Зураг 95. Туршлага судлах аялалын үеэр бичил уурхайчид Баатар Вангийн хишиг холбоо ТББ-ын үйл ажиллагааны танилцуулгыг үзэж байгаа нь



Зураг 96. Туршлага судлах аялалын багийнхан Төв аймгийн Борнуур сумын мөнгөн усгүй технологиор хүдэр баяжуулах цехийн үйл ажиллагаатай танилцав



Зураг 97. Туршлага судлах аялалын багийнхан Төв аймгийн Борнуур сумын мөнгөн усгүй технологиор хүдэр баяжуулах цехийн үйл ажиллагаатай танилцав



Зураг 98. Туршлага судлах аялалын багийнхан Төв аймгийн Борнуур сумын мөнгөн усгүй технологиор хүдэр баяжуулах цехийн үйл ажиллагаатай танилцав



Зураг 99. Нийтийн бүжгийн тэмцээний үеэр



Зураг 100. Гар бөмбөгийн тэмцээн



Зураг 101. Ширээний теннисний тэмцээн



Зураг 102. Ширээний теннисний тэмцээн

БИЧИЛ УУРХАЙЧДЫН УЛС ТӨРИЙН ИДЭВХ
САЙЖИРЧ БАЙНА
2012 оны орон нутгийн сонгууль

Бичил уурхайг тойрсон хүндрэлтэй асуудлуудыг шийдвэрлэх, нөхцөл байдлыг сайжруулах, бодлого, хэрэгжүүлэлтийн төвшинд бодит өөрчлөлт гаргах, нөлөө үзүүлэхэд бичил уурхайчид зөвхөн зохион байгуулалтанд орж үйл ажиллагаагаа хууль журмын хүрээнд явуулах нь хангалттай биш байдаг. Орон нутгийн удирдлагын түвшинд бичил уурхайчдын төлөөлөл орох нь эдгээр асуудлуудыг шийдвэрлэхэд жинтэй түлхэц болдог нь бичил уурхайн үйл ажиллагаа хөгжсөн бусад орнуудын туршлагаас харагддаг.



Иймээс 2012 оны орон нутгийн сонгуульд бичил уурхай эрхлэгчид болон бичил уурхайн ТББ-ын гишүүдээс доорх 9 аймгийн 13 сумын иргэдийн хуралд 47 нэр дэвшигч, нэг хүн аймгийн иргэдийн хуралд нэр дэвшсэн байна.

Архангай:

Цэнхэр сумын иргэдийн хуралд:

- С. Чулуунцэцэг, БУЖДҮ ТББ – Ардчилсан нам
- Т. Буянжаргал, БУЖДҮ ТББ – Ардчилсан нам

Баянхонгор аймаг:

Баян-овоо сумын иргэдийн хуралд:

- М. Мэндсайхан, нөхөрлөлийн ахлагч – Ардчилсан нам
- Б. Болдсайхан, нөхөрлөлийн ахлагч – Бие даагч
- П. Баттулга, нөхөрлөлийн ахлагч – Ардын нам
- Т. Хүрэлсүх, УЗ-ийн гишүүн – Ардчилсан нам
- С. Энх-Амгалан, нөхөрлөлийн гишүүн – Ардын нам
- Б. Отгонбаяр, нөхөрлөлийн ахлагч – Ардын нам

Галуут сумын иргэдийн хуралд:

- Б. Батжаргал, БСС ТББ – МАХН

Баянхонгор сумын иргэдийн хуралд:

- Д. Батчулуун, БСС ТББ – МАХН

Бөмбөгөр сумын иргэдийн хуралд:

- Ж. Саруул, Баянбөмбөгөр ТББ – Ардын нам (жагсаалтаар)

Аймгийн хуралд:

- Д. Сайнжаргал, ХАМОДХ ТББ-ын гишүүн, Баян-овоо сумаас – Ардын нам

Булган аймаг:

Бүрэгхангай сумын иргэдийн хуралд:

- Т. Ариунчимэг, БА ТББ – Ардчилсан нам
- М. Батцэнгэл, нөхөрлөлийн гишүүн – Ардын нам

Дархан уул аймаг:

Шарын гол сумын иргэдийн хуралд:

- О. Цэцэгмаа, БХШГ ТББ – Шударга ёс эвсэл, МАХН-МҮАН
- Д. Ганболд, БХШГ ТББ – Шударга ёс эвсэл, МАХН-МҮАН

Дорноговь аймаг:

Айраг сумын иргэдийн хуралд:

- Л. Лхагва, ЭОХХ ТББ – Ардчилсан нам
- Н. Батжаргал, ЭОХХ, нөхөрлөлийн ахлагч – Ардчилсан нам
- Б. Цогюүрэн, ЭОХХ, нөхөрлөлийн ахлагч – Ардчилсан нам
- Х. Өлзийбат, ЭОХХ, нөхөрлөлийн ахлагч – Ардчилсан нам
- Ц. Пүрэвдорж, бичил уурхайчин – Ардын нам

Дундговь аймаг:

Хулд сумын иргэдийн хуралд:

- Ж. Рэнцэнпүрэв, ТЛБ ТББ – Ардчилсан нам
- С. Хорлоо, ТЛБ ТББ – Ардчилсан нам

- Л. Золбаатар, нөхөрлөлийн ахлагч Ардын нам
- Ш. Сүхдорж, нөхөрлөлийн ахлагч - Ардчилсан нам

Сэлэнгэ аймаг:

Мандал сумын иргэдийн хуралд:

- Д. Туяа, ДМХХ ТББ – Бие даагч
- Ч. Машбат, Хувийн баяжуулах цехийн эзэн – Бие даагч
- Ж.Эрдэнэтөгс, Баяжуулах цехийн дарга – Ардын нам

Төв аймаг:

Заамар сумын иргэдийн хуралд:

- Д. Баярмаа, ЭМЭХ ТББ, Хайлааст баг – МАХН
- Ж. Уранчимэг, ЭМЭХ ТББ, Хайлааст баг – МАХН
- Д. Угтахбаяр, ЭМЭХ ТББ-ын гишүүн, Хайлааст баг–
Ардчилсан нам
- П. Мөнхболд, бичил уурхайчин, Хайлааст баг – Ардчилсан нам
- А. Цэндмаа, ТЗУ ТББ, Хайлааст баг – Ардчилсан нам
- Д. Цогтгэрэл, Заамар ТББ, Заамар сум – Ардын нам
- О. Алимаа, бичил уурхайчин, Заамар сум – Ардын нам
(жагсаалтаар)

Борнуур сумын иргэдийн хуралд:

- Б. Ууганбаяр, БУХ ТББ, ХАМО – Ардын нам
- Н. Ундрахбилэг, БУХ ТББ, ХАМО – Ардын нам
- Б. Наранцогт, ХАМО, БУХ ТББ – Ардын нам
- Р. Цогбадрах, БУХ ТББ – Бие даагч
- Д. Цэнгэл, БУХ ТББ – Бие даагч
- Б. Наранмөнх, бичил уурхайчин – Ардчилсан нам
- Ч. Оюунбилэг, бичил уурхайчин – Ардчилсан нам
- Г. Цэрэнпагма, бичил уурхайчин – Ардчилсан нам
- Х. Мягмарсүрэн, бичил уурхайчин – Бие даагч

Хэнтий аймаг:

Батноров сумын иргэдийн хуралд:

- Н. Нацагмаа, нөхөрлөлийн ахлагч – Ардчилсан нам
- П. Ариунтуяа, нөхөрлөлийн гишүүн – Ардчилсан нам
- Д. Алгирмаа, нөхөрлөлийн гишүүн – Ардчилсан нам

Эдгээр нэр дэвшигчдээс доорх 8 аймгийн 9 сум, нэг аймагт нийт 24 бичил уурхайчдын төлөөлөл сонгогдсоноос Аймгийн ИХ-ын төлөөлөгч нэг, сумын ИХ-ын дарга 2, сумын ИХ-ын тэргүүлэгч

гишүүн 3 шинээр төрж гарсан юм. Орон нутгийн сонгуульд ялалт байгуулсан эдгээр бичил уурхайчдын төлөөлөл, шинэхэн сонгогдсон гишүүд маань сум орон нутгийнхаа хөгжил, бичил уурхайн асуудлыг зохицуулах чиглэлээр бодит ажил зохион байгуулж үр дүн гаргах итгэл дүүрэн ажиллаж байна.

Архангай:

Цэнхэр сумын иргэдийн хурлын:

С. Чулуунцэцэг - Тэргүүлэгч гишүүн

Т. Буянжаргал - Төлөөлөгч

Баянхонгор аймаг:

Баян-Овоо сумын иргэдийн хурлын:

М. Мэндсайхан – Төлөөлөгч

П. Баттулга – Төлөөлөгч

Т. Хүрэлсүх - Төлөөлөгч

С. Энх-Амгалан– Төлөөлөгч

Б. Отгонбаяр– Төлөөлөгч

Аймгийн иргэдийн хурлын:

Д. Сайнжаргал – Төлөөлөгч

Булган аймаг:

Бүрэгхангай сумын иргэдийн хурлын:

Т. Ариунчимэг – Төлөөлөгч

Дорноговь аймаг:

Айраг сумын иргэдийн хурлын:

Л. Лхагва – Төлөөлөгч

Н. Батжаргал – Төлөөлөгч

Б. Цогюүрэн – Төлөөлөгч

Х. Өлзийбат– Төлөөлөгч

Дундговь аймаг:

Хулд сумын иргэдийн хурлын:

Ш. Сүхдорж - Дарга

С. Хорлоо - Төлөөлөгч

Л. Золбаатар - Төлөөлөгч

Сэлэнгэ аймаг:

Мандал сумын иргэдийн хурлын:

Ч. Машбат - Төлөөлөгч

Ж.Эрдэнэтөгс - Төлөөлөгч

Төв аймаг:

Заамар сумын иргэдийн хурлын:

Д. Цогтгэрэл - Төлөөлөгч

О. Алимаа - Төлөөлөгч

Борнуур сумын иргэдийн хурлын:

Б. Ууганбаяр - Дарга

Б. Наранцогт – Тэргүүлэгч гишүүн

Н. Ундрахбилэг – Төлөөлөгч

Хэнтий аймаг:

Батноров сумын иргэдийн хурлын:

Н. Нацагмаа – Тэргүүлэгч гишүүн

Бичил уурхайчид зохион байгуулалтанд орж хууль журмын дагуу үйл ажиллагаагаа албан ёсны болгон ТБУТ болон бусад холбогдох байгууллагуудаас зохион байгуулсан сургалт, чадавхжуулах хөтөлбөрт хамрагдсанаар тэдний нийгмийн идэвх сайжирч чадавхжсаны илрэл үүгээр харагдаж байна.

Ийнхүү сайн үйл, зохион байгуулалттай, идэвхтэй ажиллагаагаараа Монгол Улсын мянга мянган бичил уурхайчдыг тэргүүлж байгаа бичил уурхайчдын нийт хамт олон, ТББ-дад цаашдын ажилдаа улам их амжилт гаргахыг хүсэн ерөөе!

1-р хэсэг төгсөв.

Тогтвортой бичил уурхай төсөл.